

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-44
1. Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг томилох тухай асуудал	6-28
2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлт /Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/	28-44

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Хууль зүйн байнгын хорооны
12 дугаар сарын 30-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 27 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 51.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 02 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Л.Мөнхбаатар;

Чөлөөтэй: С.Амарсайхан, Х.Баттулга, М.Нарантуяа-Нара, О.Номинчимэг, Б.Пүрэвдорж, Б.Тулга, Д.Цогтбаатар;

Тасалсан: Б.Баярбаатар, С.Одонтуяа, Д.Пүрэвдаваа.

Нэг.Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг томилох тухай асуудал

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч Ч.Баянжаргал, Ц.Жавхлантөгс, Х.Эрдэм-Ундрах, Ч.Өнөржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Г.Алтанцэцэг, Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан нар байлцав.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчийн сонсголын тайланг Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Да.Цогтбаатар, Д.Ганбат, Ж.Баярмаа, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, сонсгол даргалагч Н.Алтанхуяг, нэр дэвшигч Ч.Баянжаргал, Ц.Жавхлантөгс, Х.Эрдэм-Ундрах, Ч.Өнөржаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Х.Баасанжаргал, С.Эрдэнэболд, Б.Энхбаяр, Д.Ганбат, Ц.Сандаг-Очир нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д заасны дагуу санал хураалтыг нууцаар явуулах горимын санал гаргав.

Горимын саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг үг хэлэв.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргалын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 10

Бүгд: 15

33.3 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Горимын санал дэмжигдээгүй тул санал хураалтыг илээр явуулахаар тогтов.

Ц.Сандаг-Очир: 1.Хүрэлбаатарын Эрдэм-Ундрахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 0
Бүгд: 15
100 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Чадраабалын Баянжаргалыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 4
Бүгд: 15
73.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Цэнд-Аюушийн Жавхлантөгсийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 8
Бүгд: 15
46.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Чинзоригийн Өнөржаргалыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 9
Бүгд: 15
40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлт
/Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Бямбадулам, мөн газрын Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал, зөвлөх Д.Нямбаяр, референт Б.Баярсайхан нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийн талаар Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр танилцуулав.

Дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Г.Уянгахишиг, Ж.Баярмаа, С.Эрдэнэболд нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Х.Баасанжаргал, С.Эрдэнэболд нар үг хэлэв.

Ц.Сандаг-Очир: 1.Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... эрх чөлөө, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 8
Бүгд: 15
46.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтын “... үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх ... эрх чөлөөтэй. ...” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 8
Бүгд: 15
46.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалтын “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй

асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. ..." гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 9
Бүгд: 15
40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд "Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуульд хууль бүрнээ нийцсэн байвал зохино." гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 8
Бүгд: 15
46.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 34 минут үргэлжилж, 27 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 55.6 хувийн ирцтэйгээр 17 цаг 36 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ГАЗРЫН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 12 дугаар сарын 30-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
15 цаг 02 минут.

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны гишүүдийн өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны дарга өнөөдөр томилолттой байгаа учраас миний бие өнөөдрийн хуралдааныг даргалж явуулна гэдгээ хэлье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг, Хүрэлбаатарын Баасанжаргал, Энхбаярын Батшугар, Жудагийн Баярмаа, Гонгорын Дамдинням, Борхүүгийн Дэлгэрсайхан, Ухнаагийн Отгонбаяр, Пүрэвжавын Сайнзориг, Цэндийн Сандаг-Очир, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар, Сүхбаатарын Эрдэнэболд нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэнэ.

1. Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг томилох тухай асуудал

2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлт /Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/ гэсэн 2 асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж санал асуулттай гишүүн байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг томилох тухай асуудал.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 95, 96 дугаар тогтоолоор томилогдсон Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дууссантай холбогдуулан Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасны дагуу Хууль зүйн байнгын хорооноос Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг 2025 оны 10 дугаар сард байгуулсан.

Ажлын хэсэг сонгон шалгаруулалтыг хууль журмын хүрээнд зохион байгуулж, нэр дэвшигчдийг Хууль зүйн байнгын хороонд санал болгосны дагуу Хууль зүйн байнгын хорооноос нэр дэвшигчийн томилгооны сонсголыг 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан.

Уг сонсголын тайланг сонсгол даргалагч, Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг танилцуулна. Алтанхуяг даргын микрофоныг өгье.

Н.Алтанхуяг: Эрхэм гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч Эрдэм-Ундрах, Баянжаргал, Жавхлантөгс, Өнөржаргал нартай хийсэн нэр дэвшигчийн сонсголын тайланг танилцуулъя.

Урьдчилаад хэлэхэд энэ сонсголын тайлан бол Улсын Их Хурлын албан усны цахим хуудаст байршсан байгаа. Би энийг Байнгын хорооны хурлын протоколд үлдээж унших юм.

Сонсгол түүний, үе шат явуулсан ажиллагааны танилцуулгыг би хэлье.

Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг Улсын Их Хурал нээлттэйгээр нэр дэвшүүлж, сонгон шалгаруулсны үндсэн дээр томилгооны сонсгол хийж, томилохоор заасан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1-д нь Улсын Их Хурал Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны гишүүнийг нэр дэвшүүлж томилох, чөлөөлөх, огцруулах асуудлыг Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасан журмыг баримталж хэлэлцэнэ гэж, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2-т Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд бусад 5 гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно гэж, 77 дугаар зүйлийн 77.5.2-т энэ хуулийн 77.5.1-д заасны дагуу тайланг байршуулснаас хойш ажлын 5 өдрийн дотор томилгооны сонсголын товыг зарлах гэж, Нийтийн сонсголын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30.1.1-д Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн албан тушаалд томилуулахаар Улсын Их Хуралд санал болгосон нэр дэвшигчийн талаарх томилгооны сонсгол, 30.3-д нь нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо /цаашид “Байнгын хороо” гэх/ явуулна. 30.4-д нэр дэвшигчийн сонсгол явуулахад энэ хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг баримтална гэж заасны дагуу нэр дэвшигчийн сонсголын үе шатыг баримтлан зохион байгууллаа.

1. Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшсэн Хүрэлбаатарын Эрдэм-Ундрах, Чадраабалын Баянжаргал, Цэнд-Аюушийн Жавхлантөгс, Чинзоригийн Өнөржаргал нар нь Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 6 дугаар тогтоолоор баталсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журам болон нэр дэвших тухай хүсэлтийн загварын дагуу материалаа бүрдүүлж, Байнгын хороонд ирүүлсэн болно.

2. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-т заасны дагуу Хууль зүйн байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 15, 22-ны 15, 16 дугаар тогтоолоор Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн, Өргөдлийн байнгын хорооны дарга Номинчимэг ахалж, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн ажлын албаны Хуулийн бодлогын хэлтсийн ахлах зөвлөх Оргилболд, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн зөвлөх Номингэрэл, Хууль зүй, дотоод

хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Мягмар, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Дондов, Ерөнхийлөгчийн Тамгын газрын Хуулийн бодлогын газрын дарга Мөнхболд, Шүүхийн сургалт судалгаа, мэдээлэл академийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга Дөлгөөн, Монголын өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Данзанноров, Монголын хуульчдын холбооны зөвлөлийн гишүүн Мөнхбат, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал Амарсанаа, Шихихутаг их сургуулийн Судалгааны хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Нармандах нарын бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Ажлын хэсэг маань хууль журмын дагуу сонгон шалгаруулалтын зарыг нийтэд мэдээлэх, нэр дэвших тухай хүсэлт материал хүлээн авах, ажлын хэсэг байгуулах, нэр дэвшигчдийг бүртгэж нийтэд мэдээлэх, нэр дэвшигчийн баримт бичгийг parliament.mn цахим хуудсанд байршуулах, нэр дэвшигчийн талаар мэдээлэл цуглуулах, бүрдүүлэх, ажлын хэсгийн ярилцлагыг зохион байгуулах, нэр дэвшигчийг тодруулан Улсын Их Хуралд санал болгох гэсэн 8 үе шатын хүрээнд зохион байгуулж, нууц санал хураалт явуулахад ажлын хэсгийн гишүүдийн олонхын санал авсан нэр дэвшигч Эрдэм-Ундрах 8 санал, Баянжаргал 7 санал, Жавхлантөгс 6 санал, Өнөржаргал 6 санал авсныг Хууль зүйн байнгын хороонд танилцуулсан.

Хууль зүйн байнгын хороо нэр дэвшигчтэй хийх томилгооны сонсголыг 2025 оны 12 сарын 24-ний өдөр Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд зохион байгуулахаар тов тогтоосны дагуу сонсгол зохион байгуулсан.

3. Сонсголын бэлтгэл хангах ажлын хүрээнд нэр дэвшигчийн мэдээллийг parliament.mn Улсын Их Хурлын цахим хуудсанд байршуулсан. Сонсголын товын хугацаанд сонсголд оролцогчдыг бүртгэх хуудсыг байршуулсан зарыг Улсын Их Хурлын цахим хуудас parliament.mn болон бусад сайтуудад 14 хоногийн хугацаанд давтамжтай байршуулж, оролцогч, ажиглагчийг бүртгэсэн. Зарын дагуу сонсголд оролцохоор 8 оролцогч, 1 ажиглагч и-мэйлээр бүртгүүлж, 1 иргэн асуултаа бичгээр ирүүлсэн.

4. 2025 оны 12 сарын 24-ны өдөр Хууль зүйн байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр ирц бүрдэж, сонсголыг Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг даргалж, Дамдины Цогтбаатар, Жудагийн Баярмаа, Энхбаярын Батшугар, Хүрэлбаатарын Баасанжаргал, Дашдондогийн Ганбат, Одсүрэнгийн Номинчимэг, Пүрэвжавын Сайнзориг, Лхагвасүрэнгийн Соронзонболд, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар, Гонгорын Дамдинням, Бөхчулууны Пүрэвдорж, Буяагийн Тулга, Сүхбаатарын Эрдэнэболд нарын 16 гишүүн хүрэлцэн ирж, ирц 59,3 хувь байсан болно.

Нэр дэвшигчтэйгээ танилцуулчихъя.

1 дүгээрт, Хүрэлбаатарын Эрдэм-Ундрах 1977 онд Улаанбаатар хотод төрсөн. 48 настай. 1998 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн. 2004 онд ХБНГУ-ын Фрайбург хотын Альберт Людвиг Их сургуулийн хуулийн факультетад Хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан. 2016 онд тус сургуулийн хуулийн факультетад Хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалсан. 1998-1999 онд Улсын Аюулгүй байдлыг хангах газрын дэд даргын туслах, 2005-2007 онд Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн Газрын менежмент, санхүүгийн кадастр төсөлд хуулийн зөвлөх, 2010-2011 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн Эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн тэнхимд цагийн багш, 2010-2015 онд Шпитц ХХК-д

хуулийн зөвлөх, 2016-2018 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнд Эрдэмтэн нарийн бичгийн дарга, 2017-2018 онд Швейцарын хөгжлийн агентлагийн Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн иргэдийн оролцоо 2 төсөлд Төслийн захирал, 2017-2019 онд Рендер компанид хуулийн зөвлө, 2017-2019 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимд ахлах багш, 2019-2020 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимд дэд профессор, 2020-2025 онд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, 2020 оноос одоог хүртэл Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимд гэрээт дэд профессороор ажиллаж байна.

2. Чадраабалын Баянжаргал 1981 онд Улаанбаатар хотод төрсөн. 44 настай. 2002 онд Их Засаг Их сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн. 2005 онд Их Засаг их сургуульд Хууль зүйн ухааны магистрын зэрэг хамгаалсан. 2007 онд Удирдлагын академи Бизнесийн удирдлага, удирдах ухааны магистр, 2011 онд Хүмүүнлэгийн Ухааны Их сургуульд Англи хэлний орчуулагч мэргэжлээр, 2021 онд Оросын холбооны Буриадын их сургуульд Их засаг олон улсын сургуулийн хамтарсан зөвлөлд Хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалсан. 2003-2021 онд Монголын Нотариатчдын танхимын гишүүн, Нийслэлийн тойргийн нотариатч, 2020-2025 онд Их засаг их сургуулийн Эрх зүйн тэнхимийн цагийн багш, 2022-2025 онд Глобал удирдагч Их сургуулийн Эрх зүйн тэнхимийн багш, 2021-2025 онд Монголын Нотариатын тэнхимийн ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн дарга, 2023 оноос одоог хүртэл Монголын хуульчдын холбооны Нотариатын хөгжлийг дэмжих хорооны тэргүүн, 2024 оноос одоог хүртэл Олон улсын нотариатын холбооны Азийн хэрэг эрхлэх комиссын 2025 оны ээлжит ерөнхийлөгч, Олон улсын Нотариатын Холбооны удирдах хорооны гишүүн, 2025 оноос одоог хүртэл Нотариатчийн мэргэшлийн хорооны гишүүнээр ажиллаж байна.

3. Цэнд-Аюушийн Жавхлантөгс 1979 онд Улаанбаатар хотод төрсөн. 46 настай. 2001 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийг Олон улсын эрх зүйн мэргэжлээр төгссөн. 2005 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуульд Хууль зүйн ухааны магистрын зэрэг хамгаалсан. 2019 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуульд докторын докторын зэрэг хамгаалсан. 2002-2003 онд Хасагт Хайрхан дээд сургуульд Иргэний эрх зүйн багш, 2007-2008 онд Монлекс компанид хуульч, өмгөөлөгч, 2008-2009 онд Блэк Морган компанид хуулийн зөвлөх, 2009-2019 онд “Монгол өмгөөлөгч” ХХН-д хувийн эрх зүйн секторын өмгөөлөгч, 2019 оноос одоог хүртэл “Жи Эн Ти Партнерс” компанийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

4. Чинзоригийн Өнөржаргал 1984 онд Улаанбаатар хотод төрсөн. 42 настай. 2007 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр төгссөн. 2019 онд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуульд Хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан. 2008-2010 онд Монголын Өмгөөлөгчдийн Холбооны мэдээллийн төвийн ажилтан, 2010-2012 онд Сүхбаатар дүүргийн Эрх зүйн туслалцааны төвийн өмгөөлөгчийн туслах, 2012-2013 онд Сүхбаатар дүүргийн Эрх зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч, 2014-2018 он “Соёмбо Легал Партнерс” компанийн өмгөөлөгч, 2019 оноос хүртэл өмгөөллийн “Ю Зи Сан Партнерс” компанийн үүсгэн байгуулагч, захирлаар ажиллаж байна.

5. Нэр дэвшигч Эрдэм-Ундрах, Баянжаргал, Жавхлантөгс, Өнөржаргал нар Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвших болсон үндэслэл, эзэмшсэн боловсрол, ажлын туршлагаа танилцуулсан бөгөөд ажлын хэсгийн

тайлан, нэр дэвшигчийн танилцуулгыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн, Өргөдлийн байнгын хорооны дарга Одсүрэнгийн Номинчимэг танилцуулсан.

6. Нэр дэвшигч нар Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвших болсон үндэслэл, сонгогдсон тохиолдолд хийх ажлынхаа талаар ингэж танилцуулсан.

Эрдэм-Ундрах нэр дэвшигч. Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүхийг хүний нөөцөөр хангах, шүүгчийн хараат бус байдал, хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалах, шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг хангах, шүүхэд мэдүүлэх иргэний эрхийн баталгааг хангаж, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг дээшлүүлэх, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хариуцлагатай шүүхийг төлөвшүүлэх, шүүх эрх мэдлийн байгууллагын захиргааны менежментийг хөгжүүлэх шүүхийн хүний нөөцийн чадавхыг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тасралтгүй хөгжүүлэх, шүүхийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, шүүхийн үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэхэд анхаарч ажиллах талаар.

Баянжаргал нэр дэвшигч. Монгол Улсын бүх аймаг, сумд, нийслэлд ажиллаж байгаа нотариатч, хилийн чанад дээр ажиллаж байгаа нотариатчийн үүрэг гүйцэтгэгч нарыг бүрэн цахимжуулсан ач холбогдолд хуримтлуулсан туршлагадаа тулгуурлан шүүх болон шүүгчдийн ажлын ачааллыг багасгах зорилгоор төрийн мэдээлэл солилцооны Хур систем, И-Монголиа системд холбох. Ингэснээр төрийн мэдээллийн санд байгаа иргэний мэдээллээс мэдээллийн эзний зөвшөөрлөөр хэрэг маргаанд хамаарах хэсгийг шүүгч татан авах, хэрэглэх зэрэг шаардлагатай ажлыг зохион байгуулах. Шүүх, шүүгчдийн ажиллах орчныг хөндлөнгийн шүүгч бус гишүүний оролцоотойгоор Монгол Улсад иргэдийн шударга шүүхээр шүүлгэх эрхийг баталгаажуулах, зөрчигдсөн эрхийг сэргээх, шүүхийн нээлттэй ил тод байдлыг хангах, хууль дээдлэх, шударга ёсыг нийгмийн амьдралын бүх хүрээнд төлөвшүүлэн тогтоох зорилго тавин шүүхийн бие даасан байдлыг хангах, хүний нөөцөөр хангах, шүүгчийн хараат бус байдлыг хангах, шүүгчийн нөлөөллийн мэдүүлгийн хэрэгжилтийг хангаж, хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалах, шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг хангах талаар.

Жавхлантөгс нэр дэвшигч. Төсвийн тухай хуулийг үндэслэн шүүхийн төсвийг өмнөх оноос нь бууруулах гэх мэт хандлага гүйцэтгэх эрх мэдлийн зарим байгууллагаас ажиглагдаж байгаа нь шүүх мэдлийн байгууллагыг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагатай ижил түвшинд авч үзэх сэтгэлгээ төдийлөн төлөвшиж чадаагүй байгааг илтгэнэ. Иймд Шүүхийн ерөнхий зөвлөлийн хуулиар баталгаажсан онцгой статус, нэр хүндийг хамгаалж, бүрэн хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө ажиллах, Шүүхийн ерөнхий зөвлөлийн эхлүүлээд байгаа чухал ажлуудыг үргэлжлүүлэх, залгамжлан хэрэгжүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, Гэр бүл, хүүхдийн шүүх шинээр байгуулах бэлтгэл ажил, хялбар ажиллагааны шүүхийн үйл ажиллагааг жигдрүүлэх, шүүхийн орчин нөхцөлийг сайжруулахтай холбоотойгоор хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлуудыг онцгойлон анхаарах. Шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, тэдний нэр төрийг үндэслэлгүй гүтгэлэг халдлагаас хамгаалах, хуульчдаас шүүгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааны журмыг боловсронгуй болгох, шүүгчдийн цалин, нэмэгдэл зэрэг асуудлыг анхаарах талаар.

Өнөржаргал нэр дэвшигч. Шүүгчдийн аюулгүй байдлыг хамгаалах үүднээс шүүх хуралдааныг цахимаар нэвтрүүлэх журмыг боловсронгуй болгох, шүүгч болон шүүхийн захиргааны байгууллагын ажилтнуудын ачааллыг багасгах, хүний нөөцийн олон улсын стандартыг нэвтрүүлэх, ажилтны илүү цагийг тооцон илүү цагийн хөлс тооцон авах процессыг тодорхой болгох, шүүгчдийн сургалтыг сайжруулах, шүүгчийг сэлгэн ажиллуулах журмыг боловсронгуй болгох, шүүхийн гадаад харилцааг хөгжүүлэх, дагнасан шүүхийн тогтолцооны хүрээнд шинээр байгуулагдах гэр бүл, хүүхдийн шүүгчдийн тал хувийг хуучин туршлагатай шүүгчээс бүрдүүлэх саналыг шүүхийн хамтын удирдлагад хүргүүлж ажиллах талаар дурдсан байна.

Ажлын хэсгийн тайлантай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал, Соронзонболд, Цогтбаатар, Сайнзориг, Эрдэнэболд, Да.Цогтбаатар, Ганбат, Алтанхуяг нар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүдийн асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагч Номинчимэг болон Мөнхбат, Дондов, Данзанноров, Номингэрэл, Дөлгөөн нарын гишүүд хариулт өгсөн.

Нэр дэвшигчтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Эрдэнэболд, Ганбат, Баасанжаргал, Алтанхуяг болон оролцогч Мандухайхатан, Бадамрагчаа, Баярхүү, Явуухүү, Туяа нар асуулт асууж, хариулт авсан болно. Дахиад товчиллоо.

Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Эрдэнэболд, Ганбат, Баасанжаргал, Алтанхуяг гээд Их Хурлынхаа гишүүдийнхийг энэ чинь олон нийтэд нөгөө веб сайт дээр тавьчихсан. Тэгээд та нарт гар дээр чинь байгаа учраас би хэдэн гишүүдийн саналуудыг орхичихлоо шүү.

Оролцогчдоос оролцогч Мандухайхатан шүүхэд итгэх иргэдийн итгэл буурч байгаа үр дагаварт дүн шинжилгээ хийж үзсэн эсэх, судалгаа баримттай танилцсан эсэх, олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх хүрээнд ямар ажил хэрэгжүүлэх талаар, оролцогч Бадамрагчаа шүүгчийг сонгон шалгаруулж байгаа тогтолцооны талаар, шүүхийн үр ашигтай үйл ажиллагааны талаар, шүүгчийн ачааллыг тогтворжуулах оновчтой арга замын талаар, шүүхийн тойргийн тогтолцоог дахин нэвтрүүлэх эсэх талаар, оролцогч Явуухүү нь нэр дэвшигчдийг улс төрд нөлөө бүхий хүмүүстэй харилцаа холбоотой хамтран ажиллаж байсан эсэх талаар, оролцогч Баярхүү нь нэр дэвшигчид нь хэн нэгэн этгээдийн нөлөөлөлд автахгүй, шударга ажиллаж чадах эсэх, шүүхийн боловсон хүчний нөөц бэлтгэх талаар, оролцогч Туяа хүний эрхийг хамгаалах хүрээнд хилсээр хэлмэгдсэн яллагдагч, хэлмэгдсэн иргэдийн эрх ашгийг хамгаалах асуудал дээр шүүхээс хамааралтай ямар ажил хийж байсан талаар, шүүхийн талаар, иргэдийг соён гэгээрүүлэх ажлын талаар тодруулсан.

Нэр дэвшигчээс асуулт асууж, хариулт авсны дараа Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболд, Номинчимэг болон оролцогч Мандухайхатан, Бадамрагчаа, Баярхүү, Оюундэлгэр нар үг хэлсэн.

Тухайлбал, Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүний нэр дэвшигчийн сонгол нь чухал ач холбогдолтой бөгөөд шүүх эрх мэдэл Үндсэн хуулийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлэхтэй холбоотой. Мөн хууль хоорондын зөрчлөөс шалтгаалж хүний эрх зөрчигдөж, ардчилал, эдийн засаг, чөлөөт нийгмийн дархлааг сулруулж байгаа

асуудлыг анхаарч олон нийтийн итгэл үнэмшлийг алдахгүй хэн нэгний нөлөөнд автахгүй, шүүхийн салбарыг илүү нээлттэй, ил тод болгоход идэвх санаачилгатайгаар чин шударгаар ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн Номинчимэг 2019 онд оруулсан Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлтөөр шүүх засаглалын бие даасан хараат бус байдлыг хангах тогтолцооны өөрчлөлтийг хийх бол боломжийг бүрдүүлсэн. Уг өөрчлөлт шинэчлэлийг хийх хариуцлагатай үүргийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн томилогдох хүмүүс хүлээж байгаа талаар, Шүүхийн тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд сонгон шалгаруулалттай холбоотой зохих өөрчлөлтийг оруулж, боловсронгуй болгох, мөн холбогдох Байнгын хорооны баталсан журмыг засаж сайжруулах шаардлагатай талаар, энэхүү ажлыг Хууль зүйн байнгын хороо анхаарч ажиллах нь зүйтэй талаар санал хэлж, хуралдаанд оролцсон гишүүд санал 1-тэй байгаагаа илэрхийлсэн.

Сонсголын үйл явцыг нэгтгэн дүгнэх нь:

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 76.2 ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд Хяналтын шатын шүүхээс 1, давж заалдах болон анхан шатын шүүхээс тус бүр 2 шүүгчийг, нийт шүүгчийн чуулганаас нууц санал хураалтаар сонгож бусад 5 гишүүнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр Улсын Их Хурал томилно гэж. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-д нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Байнгын хороо явуулна гэж тус тус заасны дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 129, 130, 131, 132, 133 дугаар зүйлийг тус тус баримтлан нэр дэвшигчийн сонсголыг 2025 оны 12 сарын 24-ний өдрийн 10 цаг 45 минутаас Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд зохион байгуулав.

Сонсгоод оролцсон гишүүд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүн томилогдох хүмүүс хүлээж байгаа талаар, Шүүхийн тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд сонгон шалгаруулалттай холбоотой зохих өөрчлөлтийг оруулж боловсронгуй болгох. Мөн Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоолоор баталсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулах журмыг засаж сайжруулах шаардлагатай талаар, энэхүү ажлыг Хууль зүйн байнгын хороо анхаарч ажиллах нь зүйтэй гэдэгт санал нэгдэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлд заасны дагуу сонсголд оролцсон гишүүд нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш буюу 2025 оны 12 сарын 25-ны өдөр хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонсголын тайланг гаргалаа.

Хаалттай хурлын тайланг танилцуулъя. Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигчтэй хийсэн нэр дэвшигчдийн томилгооны сонсголын тайланг Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд танилцуулахыг сонсголд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно гэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Алтанхуяг гишүүнд баярлалаа. Сонсголын тайлан болон нэр дэвшигчдийн танилцуулгыг танилцуулж дууслаа. Сонсголын тайлантай холбогдуулан мөн нэр дэвшигчдээс асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Хурдан

нэрээ өгөөрэй Сайнзориг гишүүн ээ. Эрдэнэболд юм уу. Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. Даваагийн Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Да.Цогтбаатар: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Сонгогдож орж ирсэн 4 хүнийг ер нь хувийн ямар нэгэн таньдаг мэддэг гэсэн тийм харилцаа бол байхгүй. Тэгээд дөрвүүлэнд нь амжилт хүсье. Иргэнээс ирсэн хүсэлт байгаа. Тэгээд энэ хүсэлтийг би бас нэг уншиж өгье. Сонсогдож байна уу. Би эхнээсээ явах уу. Зүгээр үү. Иргэнээс ирүүлсэн хүсэлтийг бас уншиж өгье.

Иргэн Э овогтой Б миний бие Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгох тухай нээлттэй сонсгол хэлэлцэгдэж байгааг олон нийтийн мэдээллийн хэрэгслээс олж мэдэж, энэхүү гомдлыг гаргаж байна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч Ч овогтой Б нь нотариатаар ажиллаж байсан бөгөөд түүний ёс суртахуун тус төрийн өндөр албан тушаалд тэнцэхгүй юм. Учир нь иргэн миний бие 2020 оны 6 дугаар сарын 18-ны “Орд талст” ХХК-ийн 100 хувийн хувьцааг бүхэлд нь иргэн Д овогтой Д-ээс худалдан авч, төлбөрийг нь бүрэн төлсөн байдаг. Гэтэл Д овогтой Д нь 2019 оны 3 дугаар сарын 7-ны өдөр нэр дэвшигч, нотариат Б овогтой Ч-тэй бүлэглэн дээрх гэрээнд өөрчлөлт оруулж, хуурамчаар гэрчлүүлж, улмаар Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатын тойргийн шүүхэд компанийг буцаан авахаар нэхэмжлэл гаргасан байдаг ба одоо энэ хэрэг тус иргэний шүүхэд хянагдаж, эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.

Иймд дээрх хууль бус нотлох баримтыг үйлдсэн нотариатч Ч овогтой Б-г Баянгол дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтэст гомдол гаргаж, шалгуулж байна. Иймд төрийн өндөр дээд шударга ёсны итгэл болсон шүүх засаглалын захиргааны байгууллага болох Шүүхийн ерөнхий зөвлөлд нэр дэвшиж буй Ч овогтой Б-г энэхүү албан тушаалд томилохгүй байж өгнө үү. Гомдол гаргасан иргэн Э овогтой Б.

Энэ дээр холбогдох нэр дэвшигч тайлбар хийхгүй бол энэ зүгээр яг иргэдээс ирсэн санал. Тэрнээс би яг та хэдийн сонсгол зохион байгуулсан сонсголын хуралдааны тэмдэглэл, сонсголын хуралдаан дээрээс байсан асуудлын хүрээнд та хэдийн хийж хэрэгжүүлсэн ажил, өдийг болтол дадлага туршлага тодорхой шаардлага шалгуураа хангасан гэж ойлгоод явж байгаа учраас хувийн байдлаар ямар нэгэн тийм өш хонзон ч юм уу, холбоо хамаарал асуудал байхгүй гэдгийг тодотгож хэлье. Тэгээд та хариулж өгнө үү.

Ц.Сандаг-Очир: Цогтбаатар гишүүний асуултад ажлын хэсгийн 3 уу, 2 уу. 2 номерын микрофон. Нэр дэвшигч Чадраабалын Баянжаргал хариулъя.

Ч.Баянжаргал: Сайн байцгаана уу. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Цогтбаатар гишүүний асуусан асуултад хариулъя. Яг өнөөдрийн байдлаар яг энэ асуудалтай холбоотойгоор хэн нэгэн хүн надад өргөдөл, хүсэлт, гомдол гаргасан, надад мэдэгдсэн зүйл ерөөсөө байхгүй байна. Энэ талаар дөнгөж сая анх удаа танаас сонсож байна. Тийм учраас би яг тодорхой зүйл энэ дээр хэлж мэдэхгүй байна. Анх удаа сонсож байна гэсэн үг.

Ц.Сандаг-Очир: Эрдэнэболд гишүүн асуулт асуухаасаа татгалзаж байна. Хасаад оронд нь Жудагийн Баярмаа гишүүнийг нэмчхээрэй. Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Өнөөдөр чинь юу билээ. 30 юм байна. Маргааш 31 гээд он дуусах гэж байна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулах сонсгол

явсан. Шалгаруулах хугацаа нь ч явсан. Хэд хэдэн хангалтгүй юмнууд байгаа юм. 6 хүртэл гишүүн оруулаад ирэх ёстой бол өнөөдөр ингээд 4 хүн сууж байна. Хууль зүйн байнгын хороо маань өөрөө яг ингээд тулгалтад орсон юм шиг байдалтай байна. Нөгөө хуулийн зүйл, заалт хэрэгжихгүй байна.

Нөгөө талаараа энэ комиссыг ажлын хэсгийг байгуулахдаа юу яасан юм шүү. Тэр Булгантуяа биш ээ, Улсын Их Хурлын дарга руу Хууль зүйн байнгын хорооны дарга Цогтбаатар албан бичиг явуулсан юм. Тэр дээр бол Хууль зүйн байнгын хорооноос ийм хүн толгойлох нь зүйтэй байна гэсэн албан бичгээ явуулж байсан. Тэр албан бичиг нь ч гэсэн надад байна. Гэтэл шал өөр маягаар томилогдоод, ингээд явсан байдаг. Тэр гар, хөлийн үсэг зурсан хүмүүс нь бол уул нь Их Хурлын дарга зурах ёстой л доо захирамжаараа. Журам нь тийм, хууль нь тийм. Гэтэл Их Хурлын дэд дарга, нөгөө хэл аманд ороод байгаа Булгантуяа ингээд зураад байгуулсан байх жишээтэй. Ингээд эхнээсээ л байдалтай яваад байгаа юм. Тэгээд 1 хамгийн хэл ам дагуулдаг. Нөгөө 3 засаглалын чинь 1 болсон шүүх засаглал, шүүгч нарыг сонгон шалгаруулдаг хараат бус байлгах Үндсэн хуулийн зүйл заалтыг биелүүлдэг. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулах энэ юм маань эхнээсээ булингартай бол адаг нь ч булингартай гэдэг шиг ийм зүйл болоод байгаа шүү. Тэр ажлын хэсэг оруулж ирээд тайлангаа тавьж байхдаа бас буруу ойлголт өгөөд байна лээ шүү. Тэрийг засаж залруулаад явах ёстой байх. Нөгөө талаар бол шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байна. Хэрэв шүүхийн шийдвэр нь биелэгддэггүй юм бол шүүх гэж байгаад яах юм. Би зүгээр 1 жишээ татъя. Тэр МҮИС билүү, Монгол Улсын Үндэсний Их Сургууль гэж байх шиг байгаа юм. Хэдэн жилийн өмнө билээ шүүхийн шийдвэр гарсан шүү дээ. Энэ МҮИС гэдэгтэй чинь андуурч ойлгогдоод байна. Тийм учраас Монгол Улсын гэдэг нэр томъёог хэрэглэхгүй гээд шүүхийн шийдвэр гарсан. Гэтэл тэр нь биелэгддэггүй л юм билээ. Тэгээд МҮИС гэдэг нэрээр л яваад байгаа байхгүй юу. МУИС, МУИС гээд ийм жишигтэй. Энэ талаар та нар ямар бодолтой байна.

Ц.Сандаг-Очир: Ганбат гишүүний асуултад нэр дэвшигч 4 хүн 1 номерын микрофоноос эхлээд хариулаад явчихъя.

Х.Эрдэм-Ундрах: Та бүхнийхээ энэ өдрийн амрыг эрье. Ганбат гишүүний асуултад хариулъя. Шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байна гээд МУИС болон МҮИС-ийн жишээн дээр та асууж байх шиг байна. Ер нь бол хуулиараа шүүхийн шийдвэр бол заавал биелэгдэх ёстой. Манай практикт одоогоор Эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр харьцангуй сайн биелэлттэй байдаг. Иргэний болон Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлт хангалтгүй байгаа. Магадгүй энэ шүүхийн шийдвэр биелүүлэх тогтолцоондоо бас байхыг үгүйсгэхгүй. Хуучин шигээ магадгүй Иргэний хэргийн болон Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг тусгайлсан хуулиар тухай тухайн шүүхэд нь харьяалуулж өгвөл шийдвэр биелэгдэх илүү магадлалтай болов уу гэж судлаачийн хувьд үздэг. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 3 номерын микрофон. Нэр дэвшигч Баянжаргал.

Ч.Баянжаргал: Ганбат гишүүний асуултад хариулъя. Шүүхийн шийдвэрийн тухайд гэвэл хамгийн сайн биелэгдэж байгаа шүүхийн шийдвэр бол эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр байгаа. Үүний дараа Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр бол бас харьцангуй гайгүй биелэгдэж байгаа. Өөрөөр хэлбэл 1 талд нь Захиргааны байгууллагад даалгаж байгаа учраас төрийн холбогдох албан тушаалтан байгаа учраас. Иргэний хэргийн тухайд гэвэл ялангуяа мөнгөн төлбөр,

хөрөнгө барагдуулах хэрэг дээр бол иргэний гүйцэтгэл бас хангалтгүй байгаа талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тайланд бол жил болгон удаа дараа бас дурдагдаж байгаа ийм асуудал бол бий. Тэгэхээр цаашдаа шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг боловсронгуй болгох, тэр тусмаа энэ иргэний статустай биш энэ төрийн статустай болгож Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албадлагын хүч хэрэгслээр хангах тал дээр нь илүү хүчтэй болгох тийм зохицуулалтыг оруулах юм бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага илүү бас хүчтэй болох байх. Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа бас сайжирна байх гэж ингэж боддог. Нөгөө талаас нөгөө хэрэг маргааныг шийдвэрлэх гэхээсээ илүү нөгөө эвлэрүүлэн зуучлах байдлаар талуудыг тохиролцуулж хэрэг маргааныг шийдвэрлэх энэ хувь хэмжээг өсгөх юм бол шийдвэр гүйцэтгэл дээр ирж байгаа хэрэг маргааны тоо бол багасна. Харьцангуй шийдвэр гүйцэтгэх ажиллагаа бол тухайн төлбөр төлөгчийн сайн дурын үндсэн дээр гүйцэтгэх ийм бололцоо бас бүрдэнэ. Ийм учраас энэ хэрэг маргааныг эвлэрүүлэн гэдэг юм уу шүүхийн бус журмаар хянан шийдвэрлэх энэ арга замыг бас хөгжүүлэх юм бол энэ шүүхийн ачааллаас гадна Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ачааллыг бас бууруулах, шүүхийн шийдвэр биелэгдэхэд бас сөрөг нөлөө үзүүлэхгүй байх ач холбогдолтой гэж бас үзэж байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 4 номерын микрофон. Нэр дэвшигч Цэнд-Аюушийн Жавхлантөгс.

Ц.Жавхлантөгс: Баярлалаа. Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Ганбат гишүүний асуултад хариулъя. Шүүхийн шийдвэр биелэгдэхтэй холбоотой асуудлын талаар дараах зүйлийг тодруулж хэлье. 1 дүгээрт нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилогдсон тохиолдолд ер нь бол Ерөнхий зөвлөлийн гишүүн маань яг хуулиар олгогдсон үндсэн чиг үүрэг бол шүүн таслах ажиллагаанд ямар нэгэн байдлаар оролцох ийм оролцоо байхгүй байх ёстой. Гэсэн хэдий ч ер нь өмгөөлөгчөөр ажиллаж байсан энэ тодорхой хугацааны туршлага, энэ нөхцөл байдал дээр бол бол шүүхийн шийдвэр зайлшгүй биелэгдэх нь бол өөрөө ийм хууль ёсны асуудал. Зүгээр шүүхийн шийдвэрийн биелэлттэй холбоотойгоор илүү энэ дээр анхаарал тавьж ажиллах газар нь бол Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар. Ер нь бол миний бодлоор өмнө нь бол урамшуулалтай холбоотой асуудал юмнууд бол шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа дээр бол их эрчимтэй хийгддэг байсан. Энэ нөхцөл байдлыг бас зайлшгүй сэргээж, илүү их хурдацтай гэдэг юм уу, илүү энэ нөхцөл байдал дээр анхаарах боломж нөхцөл байдлаар бас ажилтан, албан хаагчдыг хангах, үүнтэй холбоотойгоор шийдвэрийн гүйцэтгэл бол тодорхой хэмжээнд эрчимжих ийм нөхцөл байдал боломжтой байна гэж ингэж хэлэхээр байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 5 номерын микрофон. Нэр дэвшигч Чинзоригийн Өнөржаргал.

Ч.Өнөржаргал: Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой асуудлаар бол энэ удаагийн Улсын Их Хурал бол бас тодорхой үр дүнтэй ажлыг эхлүүлчихсэн явж байна гэж бодож байна. Номинчимэг гишүүнээр ахлуулсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөл бол бас хэлэлцүүлгийн шатад амжилттай явж байгаа гэж бодож байна. Тэгэхээр хууль тогтоогчийн зүгээс бас энэ шүүхийн шийдвэрийг биелүүлэх, гүйцэтгэхтэй холбоотой асуудалд илүү анхааралтай хандаж, хууль тогтоомжийг батлах шаардлагатай байгаа, тулгамдсан асуудлын 1 байгаа гэдгийг хэлмээр байна.

2 дугаарт бол манай Шүүхийн ерөнхий зөвлөл өөрөө захиргааны байгууллага. Одоо шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг биелүүлэх талаар шүүхийн захиргааны ажилтнууд Шүүхийн ерөнхий зөвлөлийг шаардсан ийм нөхцөл байдалтай байгаа. Өөрөөр хэлбэл шүүхийн захиргааны ажилтнуудын цалингийн зөрүүний асуудал ингээд шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа нь явагдаж амжаагүй энэ хүмүүс ингээд шаардсан байдалтай байгаа. Тэгэхээр ер нь бол Шүүхийн ерөнхий зөвлөлд шүүхийн захиргааны байгууллага болохынхоо хувьд шүүхийн шийдвэрийг бас гүйцэтгэх, биелүүлэх, хүндэтгэн үзэх ёстой гэсэн ийм байр суурьтай байна.

Ц.Сандаг-Очир: Ганбат гишүүн тодруулга 1 минут.

Д.Ганбат: Ингээд та бүхэн бас ёс суртахууны хувьд бүх талаараа л нээлттэй, шилэн тунгалаг л байх ёстой л доо. Зарим 1 нь сахилгын зөрчил авчхаад тэрийгээ тэр юман дээрээ бичээгүй, мэдүүлээгүй л гэж байна. Ийм байж болохгүй. Бас олон нийтийн сүлжээгээр ил тод, нээлттэй явдаг болчихсон байна. Бас ганц 1 хүмүүс дээр шүүмжлэл их явж байна. Өөрсдөө уншиж харсан л байлгүй. Тэр талаар ямар бодолтой байна вэ.

Нотариатч 1 хүн яваад байх шиг байна. Энэ хүн маань тэр шүүх танхимд, тэр шүүхийн процесс, үйл ажиллагаатай хэр танилцсан хуульч гэж үзэх вэ таныг гэх мэтчилний ийм асуултууд байна. Улам-Ундрах билүү, Улам-Өрнөх билүү. Бусдаас нь би асуучихъя. Эрдэм-Ундрахаас надад асуугаад байх юм алга. Нөгөө 3-аас нь энэ асуултыг тавьчихъя.

Ц.Сандаг-Очир: Ганбат гишүүний асуултад ажлын хэсгийн 3 номерын микрофон.

Ч.Баянжаргал: Ганбат гишүүний асуултад хариулъя. Сахилгын хариуцлагыг бичсэн эсэх асуудал дээр бол тухайн хүн нь өөрөө хариулт өгөх нь зүйтэй байх гэж бодож байна.

Мэдээж олон нийтэд тавигдсан мэдээлэл дээр бол иргэд шүүмжлэлтэй, сайшаалтай янз бүрээр бол хандаж байна. Тэр мэдээллийг бас авсан гэдгийг хэлье. Миний бие нотариатчаар ажиллахаас гадна өмгөөлөгчөөр 2005-2011 онд 6 жил бас ажилласан. Процессын ажиллагаанд оролцсон. Шүүхийн үйл ажиллагаанд бас оролцсон гэдгийг бас хэлмээр байна. Нөгөө талаас шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийдэг, дээр нь судалгааны ажил эрхэлдгийн хувьд Улсын дээд шүүхийн гарч байгаа тогтоол шийдвэрийг байнга дандаа хардаг. Дээр нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн тайлан, шүүхийн жил болгоны үйл ажиллагааны тайланг харж байгаа. Тэгэхээр шүүхийн процесст 1 дүгээрт оролцож байсан, 2 дугаарт онолын хувьд гэдэг юм уу, судалгааны хувьд бас шүүхийн үйл ажиллагаатай холбоотой холбогдох судалгааг хийдэг. Нээлттэй нийгэм форумын санхүү /минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 5 номерын микрофон. Нэр дэвшигч Өнөржаргал.

Ч.Өнөржаргал: Нэр дэвшигчийн хувьд сонгон шалгаруулалтын үед сөрөг мэдээлэл буюу сахилгын шийтгэлтэй эсэх асуудал дээр надаас ажлын хэсгийн гишүүн бол тайлбар авсан. Энэ сануулах сахилгын шийтгэл нь бол Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүх бус гишүүний сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд бол нуусан зүйл байхгүй байгаа гэдгийг хэлмээр байна.

Шүүхийн ерөнхий зөвлөл бол шүүхийн захиргааны дээд байгууллага байгаа. Хуульчийн хувьд шүүн таслах ажиллагаанд тодорхой эрх, үүргийг хэрэгжүүлэн ажилладаг. Шүүхийг нээлттэй, ил тод байлгах, шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах гэх зэргээр өөрийн бас үзэл бодлыг байнга илэрхийлдэг байсан ийм хуульчдын 1 байгаа. Шүүхийн захиргааны байгууллагад нээлттэй байх хүрээнд болон шүүгчдийг бусад хуульчдаас шилж олох, шүүхийн энэ үйл ажиллагаанд тодорхой хэмжээнд .../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Одоо Баярмаа гишүүн асуултаа асууя.

Ж.Баярмаа: Та бүгдийн энэ өдрийн амрыг эрье. Тэгээд энэ Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшигч 4 хуульчид орж ирсэн байна. Тэгээд ерөнхийдөө энэ томилгооны сонсгол маш чухал зүйл гэдэг нь ажиглагдаж байна. Яагаад гэвэл маш нээлттэйгээр, ёстой нөгөө далан булчирхайг нь тоочуулж ингэж асуудалд хандаж байгаа нь бол зөв, зүйтэй гэж харж байгаа юм. Тэгээд энэ бол журмын дагуу, хуулийн дагуу 11 гишүүний нууц санал хураалтаар та бүхэн чинь ингээд шалгараад ороод ирсэн байна л даа. Тэгээд энэ 11 гишүүний бүрэлдэхүүнийг харахаар олонхоос байна. Улсын Их Хурал дахь олонхын төлөөлөл ажлын албанаас нь, цөөнхөөс нь, салбарын яамны Төрийн нарийн бичгийн дарга, академик байгууллага буюу МУИС, хувийн дээд сургууль Шихихутаг гээд. Ингээд Хуульчдын холбоо, Өмгөөлөгчдийн холбоо, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Шүүхийн гээд ингээд бүхий л энэ салбартай холбоотой төрийн болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл оролцоод, та 4-ийг шалгаруулсан юм байна.

Миний сонссоноор 24 хүн материалаа өгсөн гэж ойлгосон. Тэгэхээр энэ 24 хүнээс та 4 ингээд шалгараад ороод ирнэ гэдэг чинь энэ 11 хүний шалгуурыг ямар ч байсан даваад ороод ирсэн юм байна гэж би бодож байна. Бүхэл бүтэн 24 хүнээс. Тэгэхээр тэр 20 хүн бол тодорхой хэмжээнд шаардлага хангаагүй учраас л хоцорсон юм болов уу гэж би бас бодоод байна л даа. Одоо 6 хүртэлх гээд манай Ганбат гишүүн яриад байгаа. Тэгэхээр нөгөө 2 хүн хүртэл энэ босгыг давж чадаагүй юм байна гэдэг чинь өөрөөр хэлбэл маш нарийн шалгуураар орсон гэж би бол ойлгоод байна. Тэгэхээр яах вэ, судлаач хүмүүс ч байна. Нотариатч хийж байсан хүн, өмгөөлөгч хийж байсан, нийгмийн идэвхтэй гээд янз бүрийн төлөөлөл байх шиг байна л даа та 4-ийг харахад. Тэгээд сая Ганбат гишүүн ч гэсэн дурдлаа. Хамгийн чухал зүйл бол ёс суртахуун. Ер нь бол энэ сонсгол хийнэ гэдэг чинь бид нар хүнд итгэхгүй болчихоод байгаагийн л илрэл шүү дээ. Хувь хүний ёс суртахуунд найдах аргагүй болчихсон ийм нийгэм учраас сонсгол хийж байж хамаг зүйлийг нь яриулж байж, асууж байж томилдог болчихоод байгаа шүү дээ. Тэгэхээр ийм их өндөр шалгуурыг давж та бүхэн сонгогдох юм бол ёс суртахууны хувьд буюу яг тэр өөрийнхөө хариуцсан ажлын хүрээнд маш шударгаар ажиллана гэсэн тийм баталгаа байна уу. Тэгээд янз бүрийн асуудал бас яригдаад л байна л даа. Зарим нэг нь ийм ийм асуудалтай байсан. Зарим нь болохоор үгүй байсан гээд ингээд бүх тайлбарууд нь хийгдээд яваад байна л даа. Гэхдээ та бүхэн өөрсдийгөө нэр дэвшүүлсэн. Тийм учраас яг энэ маш шударгаар, ёс суртахууны өндөр хариуцлагатайгаар ажиллана гэдэгтээ итгэлтэй байгаа эсэхээ албан ёсоор хэлж өгнө үү гэж хүсэж байна.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 1 номерын микрофон. Нэр дэвшигч Эрдэм-Ундрах.

Х.Эрдэм-Ундрах: Баярмаа гишүүний асуултад хариулъя. Ёс суртахуунтай, шударга ажиллах баталгаа, итгэл байна уу гэж та асуулаа. Миний хувьд өнөөдрийг

хүртэлх ажил, амьдралын зам мөр маань миний өөрийн дотоод итгэл үнэмшил, тэгээд ёс зүйд тулгуурлаж өнөөдрийг хүртэл би ер нь бол аль болох зөв шударга байхыг хичээж ажиллаж ирсэн. Тийм ч учраас улс үндэстэн даяар ингээд нээлттэй сонсгол хийж, 7 булчирхайгаа тоочуулахад надад айх зүйл бас байгаагүй. Яагаад гэвэл би өнөөдрийг хүртэл үнэн зөв явж ирсэн гэдэгтээ итгэлтэй байдаг.

Ц.Сандаг-Очир: Нэр дэвшигч ажлын хэсгийн 5 номерын микрофон. Өнөржаргал.

Ч.Өнөржаргал: Баярмаа гишүүний асуултад хариулъя. 2007 онд хууль зүйн сургуулийг төгсөөд, 2009 оноос эхлээд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа. Энэ хугацаанд бол 1 удаа сануулах сахилгын шийтгэл авсан байна. Энэ бас манай өмгөөлөгчийн ёс зүйн дүрэмд заасан байдаг. Ёс зүйн шийтгэл биш зөвхөн тэр материаллаг хууль тогтоомжийгоо буруу тайлбарлаж, үйл ажиллагаанд хэрэглэсэн байна гэдэг ийм асуудлаар байсан гэдгийг хэлье.

Миний хувьд Шүүхийн ерөнхий зөвлөл гэдэг энэ төрийн захиргааны шүүхийн захиргааны дээд байгууллагад ажиллахдаа шүүхийн захиргааны үйл ажиллагааг Үндсэн хуулийн зарчимд заасны дагуу Шүүхийн тухай хуульд заасны дагуу захиргааны шийдвэр гаргах үйл ажиллагаандаа хөндлөнгийн хараат бусаар, ёс зүйтэй ажиллахаа бол илэрхийлж байна. Ийм чин шударгаар ажиллах хуульчийн итгэл үнэмшил, ёс зүйд төлөвшсөн гэж өөрийгөө үзэж байна. Сануулах сахилгын шийтгэл авсан үйл ажиллагаа бол 2 жилийн өмнө байгаа. Энэ нь бол энэ сонгон шалгаруулалтын үйл ажиллагаанд тодорхой шууд нөлөөлөл үзүүлэхгүй гэж үзсэн. Энийгээ ч би нуухгүйгээр энэ үйл ажиллагаанд оролцож байгаа гэдгээ илэрхийлмээр байна.

Ер нь бол шүүхийн захиргааны байгууллагын Үндсэн хуулийн зарчим шүүгч бус гишүүнийг оруулж ирсэн нь хуулиараа хуульчилсан зарчим нь бол шүүгчдийн дийлэнх олонх байдаг байсан шүүгчдийн нийтлэг эрх ашиг бий болохоос сэргийлэх, нөгөө талаасаа бас шүүгч бус гишүүд нь ихэнхдээ хуульч болчих юм бол бас хуульчдын ашиг сонирхол, давуу байдал үүсэхээс сэргийлээд эрх зүйч гэдэг ийм мэргэжил, эрх зүйч гэдэг ийм шалгуурыг тавьж өгсөн байгаа. Энэ ч гэсэн дараа дараагийн сонгон шалгаруулалтад яг энэ чиглэлээр дагнаж ажилладаг төрийн бус байгууллагын гишүүд ч гэсэн оролцож ажиллах боломжийг нээсэн үйл ажиллагаа гэж бодож байгаа. Эцэст нь дахиад хэлэхэд бол би ёс зүйтэй энэ үйл ажиллагааг эрхлэн явуулахаа дахин илэрхийлж байна.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 4 номерын микрофон. Жавхлантөгс нэр дэвшигч.

Ц.Жавхлантөгс: Баярмаа гишүүний асуултад хариулъя. Миний бие өмгөөлөгчийн мэргэжлээр 23 жил ажилласан. Энэ ажиллах хугацаандаа ямар нэг байдлаар сахилгын болоод ёс зүйн хариуцлага хүлээж байгаагүй. Энэ хугацаандаа мэргэжлийн ёс зүйгээ өндөр хэмжээнд баримталж өнөөдрийг хүртэл ингэж ажиллаж ирсэн. Тэгэхээр энэхүү албан тушаалд хэрэв томилогдох юм бол мэргэжлийн ёс зүйгээ өндөрт барьж ингэж ажиллах бүрэн итгэл миний хуульчийн хувьд төлөвшсөн гэж ингэж үзэж байгаагаа бас илэрхийлмээр байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 3 номерын микрофон Баянжаргал.

Ч.Баянжаргал: Баярмаа гишүүний асуултад хариулъя. Миний бие хуулийн салбарт 23 жил ажиллаж байна. Энэ хугацаанд ганцаараа, дээр нь багаар, дээр нь багшлах гэх мэт маш олон хэлбэрээр ажиллаж байсан. Тэгээд энэ хугацаанд ямар нэгэн сахилгын шийтгэл бол хүлээж байгаагүй. Дээр нь өөрөө сайн дураараа Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүд нэр дэвшихдээ бас юуг баримталж ажиллах ёстой, би энэ ажлыг хийж чадах уу гэж өөрөөсөө асуусан. Тэгээд ямар ч байсан 23 жил хөдөлмөрлөхдөө шударга ажиллаж чадсан. Энд бас шударга ажиллаж чадна гэсэн итгэл үнэмшилтэй учраас бас нэрээ дэвшүүлсэн. Тэгээд хэрвээ та бүхний итгэлийг хүлээгээд томилогдох юм бол шударга, ёс зүйг бас чанд баримтлан ажиллах болно гэдгийг бас илэрхийлж байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Би ганц асуулт асууя. Алтанхуяг даргаас. Ажлын хэсгийн даргаас. Энхбаяр сайд, та бид 3 2021 онд Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулж байсан. Ингээд хууль хэрэгжээд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүдийг Улсын Их Хурал, Байнгын хороогоор томилгооны сонсгол хийж ингэж томилдог болсон. Эхний сонгогдсон гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусаад, дараагийн бүрэн эрхийн хугацааг томилгооны сонсголыг хийж оруулж ирж байна. Тэгээд энэ томилгооны сонсгол яг бид нарын анх хууль бичиж байхдаа үзэл баримтлал яг агуулгаараа хэрэгжиж чадаж байна уу. Энэ яг үнэхээр хараат бусаар хөндлөнгийн нөлөөлөлгүй тэгээд шударга гэдэг юм уу, зөв хүмүүсийг сонгон шалгаруулж чадаж байна уу бид нар. 24 хүнээс 4 хүнийг оруулаад ирлээ. Цаана нь 20 хүн нь 5 хүн, 6 хүн орж ирэх бололцоотой боловч ийм бололцоо байхгүй байсан юм уу. Ер нь өнгөрсөн 4 жилийн хугацаанд ажилласан томилгооны сонсгол хийгдсэн хүмүүс ер нь бас хэр сайн ажилласан гэж бодож байна. Асуудал юм гаргаж байсан уу. Ер нь яг энэ томилгооны сонсгол ер нь яг хараат бусаар, яг үзэл баримтлалын хүрээнд зөв хүмүүсийг сонгон шалгаруулж чадаж байна уу л гэж асуух гээд байна.

Яагаад гэхээр энэ хүмүүс тэнд очоод шүүгч нарыг сонгон шалгаруулах ажлыг энэ хүмүүс оролцож хийнэ. Мөн сургалтын асуудлыг хариуцна, захиргааны асуудлыг нь хариуцна. Ингээд ирэхээр энэ хүмүүсийг бид нар яаж зөв хүмүүс сонгосон эсэхээс хамаарч цаашдаа шүүгч нарын асуудлыг ярих асуудлууд үүсэж байна. Тийм учраас энэ томилгооны сонсгол хийж байгаа энэ процесс ажлын хэсэг байгуулагдахаас авхуулаад өнөөдрийг хүртэл ингэж оруулж ирж байгаа энэ процесс ер нь танд яг үнэнийг хэлэхэд анхнаасаа яг энийг нь засчихмаар юм байна. Энэ нь амьдрал дээр нь нийцэхгүй байна. Болохгүй байна гэсэн юмнууд байна уу, үгүй юу гэдгийг та ажлын хэсгийн даргаар ажилласан хүний хувьд хариулаач. Алтанхуяг гишүүний микрофон.

Н.Алтанхуяг: Энэ хуульд анх өөрчлөлт оруулаад, Энхбаяр гишүүн та бид хэдэд оруулсан тэр өөрчлөлт том дэвшил болсон. Юмыг бас үгүйсгэж болохгүй. Хуучин хэн яаж томилоод байгаа нь мэдэгдэхгүй явчихдаг байсан юмыг нэг нээлттэй болгоод эхлээд хийсэн. Хамгийн анхныхыг нь хийсэн шүү дээ. Ингээд гайгүй болоод явах байх гэсэн саяын томилгоо дээр хамгийн гол бид нарын хийсэн алдаа гэдэг нь бид нарын хийсэн 2, 3 тийм дутуу юм байна гэж би харж байгаа.

1 дүгээрт Улсын Их Хурал энэ хүмүүсийг гаргах ёстой. Гэтэл бид нар ажлын хэсэг байгуулаад, ажлын хэсэгт хамаг эрх мэдлээ өгөөд, ганц Их Хурлын гишүүн тавьчихсан. Тэгээд 10 хүнийг бид нар кнопдож болно, болохгүй гэж байгаа. Би бол жишээ нь тэр 10-аас чинь таних хүн байхгүй шүү дээ. Ингээд явуулчихсан чинь бид нар хуульдаа бас тэр үедээ юу гэж ярьж байсан гэхээр квот нь 4 байх юм бол 6 хүртэл хүнийг оруулж ирнэ гээд тодорхой өгчихсөн байхгүй юу. Тэгсэн чинь яг 4 хүнийг нь аваачаад 4-д нь тааруулаад 4 хүн өгчихсөнөөс маргаан эхэлсэн. Энэ бол

ажлын хэсгийн буруу гэхээсээ илүүтэй бид нарын гаргасан хууль журмуудыг бас өөрөөр ашиглах боломж бүрдчихсэн юм биш үү гэдэг хардлага бий болсон шүү дээ манай Байнгын хороо дээр. Хардлага шүү. Өөрөөр хэлбэл яагаад тэгж байгаа вэ гэхлээр хууль зүйн хүний хувьд аваад үзэх юм бол 4 хүн дээр чинь 4-ийг л өгсөн юм шүү дээ. Үгүй ээ, та нар яахаараа 6 гаргаж ирэхгүй байгаа юм гэхээр олонхын саналыг 4-өөс цааших нь аваагүй шүү дээ гэхихээр чинь бид нар бас нөгөө хууль журам тогтоогчид чинь ингээд үг дуугүй болчихоод би бол дуугарч чадахаа больчихоод байгаа юм.

Гэхдээ цаана нь үлдсэн 20 гаруй хүнээс бас олон гомдол ирсэн. Та нар ер нь яаж шалгаад байгаа юм. Хууль ч биш хүн бараг өмнө нь сууж байгаад тэгээд энийг шалгаруулах юм чинь ороод байна шүү дээ. Та нар ер нь энэ хүмүүсээ яаж бүрдүүлээд байгаа юм. Тэгээд би бас яаж бүрдүүлж байгаа билээ гээд буцаагаад хуулиа харахаар бид нар тэгээд л биччихсэн байгаа байхгүй юу. Тэр олонхын бүлгийн 1 нөхөр орно. Цөөнхийн бүлгийн 1 нөхөр. Яагаад ч бид нар тэгчихсэн юм мэдэхгүй. Тэгээд өмнөх 21 нь бол тэгээд болчихсон. Тэгэхээр байгаа юмаа хэдүүлээ өшөө жаахан сайжруулах ёстой. Энийг сая манай сонсгол, тэр сонсголын өмнө тэр 24-өөс 14-ийг шалгаад байгаа чинь Номинчимэг гишүүний ахалсан ажлын хэсэг. Би бол гаргаад ирчихсэн 4 дээр чинь сонсгол явуулахыг даргалж байгаа. Түүнээс биш би дарга хийгээгүй. Хурал даргалсан. Тэгээд энэ дээр манай гишүүд ингэж ярьсан. Сонгон шалгаруулалттай холбоотой зохих өөрчлөлтийг оруулж, боловсронгуй болгомоор байна. Хууль зүйн байнгын хорооны тогтоолыг өөрчилмөөр байна. Ер нь Хууль зүйн байнгын хороо энэ дээр жаахан янзалмаар байна. Энэ 4 дээр бол сонсголоо хийчихсэн. Бүх процесс нь явчихсан. Тэгэхдээ хамгийн гол хар бол 4 дээр 4-ийг шалгаруулсан. Дахиад ийм алдаа /минут дуусав/

Ц.Сандаг-Очир: 1 минут Алтанхуяг гишүүн гүйцээгээд хариулчихъя.

Н.Алтанхуяг: Би байгаа байдал хэлж байна шүү. Юмаа жаахан сайжруулъя гэж. 24 хүн ингээд нэр дэвшсэн чинь илтгэгч гишүүн бас дахиад л нөгөө хууль дээр л байгаа байхгүй юу. Илтгэгч гишүүн гээд томилчихсон. Тэгээд хэд вэ, 11 хүнд чинь дунджаар 2 хүн оногдоно биз дээ. Тэр 2 хүн нь яаж сонгогдоод байгаа юм. Бид нар хууль дээр гоё бичиж байгаа шүү дээ. Тэгээд нөгөө санаандгүй байдлаар сугалаагаар хийнэ гэсэн монголын 11 хүний санаандгүй юм ч гэж юу байдаг юм гээд л бид нар ийм амьдралын бодитой бодитой юмтай ингээд тулгарчихсан. Дээр нь бас дахиад ийм алдаа байна лээ. Одоо саяын сонсгол дээр ажиглагдсан. Өөрийнхөө тухай бүх мэдээллийг өөрснөө гаргаж өгөх ёстой юм байна лээ. Гэтэл шүүхээр шийдэгдээгүй жижиг сажиг янз бүрийн маргааны асуудлыг бид нар нэхээгүй учраас эд нар тайлагнаагүй, хэлээгүй. Гэтэл сонсгол явж байх хооронд наад нөхөр чинь тэгсэн байхгүй юу, ингэсэн байхгүй юу гээд энэ баахан ингэсэн. Иймэрхүү дутагдлууд гарсан. Энийг засаж залруулж, сайжруулж явах нь манай Байнгын хорооны ажил юм.

Ц.Сандаг-Очир: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Нэр дэвшигчтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Ганбат гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүн ирцийн дарааллаар орж байна.

П.Сайнзориг: Баярлалаа. Яах вэ Үндсэн хуулийнхаа үзэл санааг амилуулаад, тодорхой тооны хүмүүсийг бид нар хууль тогтоомжид заасны дагуу томилох энэ процесс явж таарна. Би асуулт бол байхгүй. Сонсгол дээр 4 нэр дэвшигчээс асуудгаа асуучихсан. Гол асуудал юу вэ гэхээр сая Алтанхуяг даргын хэлж байгаа л байгаа юм. Бид нар Шүүхийн тухай хуулийг бас тодорхой цаг хугацаа өнгөрчихлөө.

Тэгэхээр энийг бас болохгүй байгаа заалтуудыг нь ч юм уу, эсвэл сайжруулах заалтуудаа бас дүгнээд, сайжруулах ажлыг хийх ёстой. Үүнтэйгээ холбоотойгоор сонгон шалгаруулалтын процессыг ч гэсэн жоохон тодорхой болгоё гэдэг дээр бол ярьсан шүү. Энийг бас Хууль зүйн байнгын хорооны нийт гишүүддээ бас сонордуулж байгаа юм. Энийг хийж байж цаашдаа шүүх эрх мэдлийн хүний нөөцийг сонгон шалгаруулалт бас шударга явагдах юм байна гэдэг зүйл байгаа. 1 дүгээрт.

2 дугаарт яах вэ, энэ шүүхийн захиргааны байгууллага болох Шүүхийн ерөнхий зөвлөлд ажиллах хүмүүсийг зөвхөн бид нар эрх зүйч, хуульч дээр бас хараад байж болохгүй юм байна гэдэг зүйлийг би зүгээр харж байна. Ер нь зүгээр болж өгвөл хүний нөөцийн чиглэлээр бас мэргэшсэн, төсөв, санхүүгийн зохиож хэлэлцүүлж батлуулах энэ процесст оролцсон ийм хуульчид бас баймаар юм байна. Эсвэл эдийн засагчид ч юм уу. Тэгэхгүй энэ Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажил маань бол тэр олон хуульчдаас шүүгчийг шилж болохоос гадна гол нь энэ шүүх эрх мэдлийн систем ажиллах тэр дэд бүтэц, тэрийг дагасан төсөв санхүүгийн асуудлыг шийдүүлж чадах ур чадвар л хэрэгтэй байгаа байхгүй юу. Гэтэл зүгээр иймэрхүү бас юмнууд бол ажиглагдаж байна. Илүү их хуульч background-тай талдаа ингээд байгаа учраас бид хэд Алтанхуяг дарга энэ тэрийн хэлж байгаа дээр би бас энийг цаашдаа ер нь анхаарах ёстой юм байна гэж хэлж байна.

Тэгээд та 4-ийн үр дүн яаж ч гарч болох магадлалтай. Тэгэхдээ бас иргэний зориг гаргасанд урьдчилаад бас талархал баяр хүргэхийе. Ер нь бол юу гэдэг юм заавал дэмжинэ гэсэн үг бас биш. Тэгэхдээ бас зарим зүйлүүд бол үнэхээр нээлттэй сонсголын үе дээр бас жоохон жоохон зохимжгүй мэдээллүүд орж ирсэн. Энийгээ илэн далангүй эрт л хэлэх ёстой байсан. Тийм учраас бас дараа дараагийн юмнууд дээр анхаарах ёстой юм байна.

2 дугаарт энэ шүүгч бус гишүүний сонгон шалгаруулалт дээр Улсын дээд шүүхийн төлөөлөл орж ирж, сонгон шалгаруулалтын ажиллагаанд оролцсоныг анхаарах ёстой. Судалгааны байгууллагын нэрээр Улсын дээд шүүх орж ирж эд нарыг шалгаруулсан шүү. Тэгэхээр ийм зүйл бол байж болохгүй гэдэг зүйлийг протоколд үлдээмээр байна.

Ц.Сандаг-Очир: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуултаа асууя. Үгээ хэлье.

Х.Баасанжаргал: Нэр дэвшигч нартай холбоотой нэг үг, дээрээс нь санал хураалтын процесстой холбоотой бас үг хэлэх нь зөв байх. Одоо бид нар чинь нууцаар санал хураана. Тийм үү. Байнгын хороон дээр илээр юм уу. Хувь хүнтэй холбоотой ч гэсэн илээр юм уу. Энэ болох юм уу дэгийн хуулиараа. Илээр юм уу. Чуулган дээр бас илээр юм уу. Ил санал хураалт юм уу. Тэгвэл энэ чинь тэгээд хувь хүнтэй холбоотой асуудлыг илээр санал хурааж болох юм уу бид нар чинь. Энэ асуудлыг бид нар анхаармаар байна.

2 дугаарт яах вэ, хэрвээ нууц санал хураалт бол бид нар хэдийгээр ингээд дэлгэц дээр нууцаар санал өгч байгаа ч гэсэн хэн ногооныг дарж байна, хэн улааныг дарж байна гэдэг нь камераар харагдаад байгаа байхгүй юу. Ийм нууц санал хураалт гэж бас юу байх вэ дээ. Энэ тэр гээд бид нар жаахан процессын хувьд засах юмнууд байна. Ил гэдгийг нь ойлголоо. Тэгэхдээ энэ чинь ил байж болох юм уу гэдгээ хэдүүлээ харах ёстой байх.

2 дахь нэр дэвшигч нартай холбоотой асуудал яах вэ би цахимаар урьдчилаад 3, 4 асуулт цахимаар нээлттэй тавиад, та нараас би чуулган дээр орж ирэхэд Байнгын хороо дээр энэ 4 асуултыг асууна. Яагаад урьдчилаад нээлттэй ил тавьж байгаа вэ гэвэл судлаад, уншаад орж ирээд, тэгээд маш үр дүнтэй, үр нөлөөтэй ийм мэтгэлцээн бодлогын ийм санал солилцоо болоосой гэж бодож би бол асуултаа 2 долоо хоногийн өмнө нээлттэй цахим дээр тавьсан. Манай нэр дэвшигчид бүгдээрээ танилцсан байсан. Тэгэхдээ харамсалтай нь хэн нь ч яг нөгөө бодож байсан санаанд бол хүрээгүй. Гэхдээ заавал миний санаанд хүрэх албагүй. Гэхдээ ядаж шүүхийн төсвөө ч гэсэн хэн аль нь сүүлийн 3 жилийн шүүхийн төсвөө хараад ороод ирэхгүй яав даа гэдэг ийм бодол бол яалт ч үгүй байсан шүү. Тэгэхээр үг хэлэх дээрээ бол би бас энийг хэлэх нь зөв байх гэж бодож байна. Цаашид энэ шүүхийн төсөв буюу эдийн засгийн бие даасан байдал, шүүхийн улс төрөөс хараат бус байдал гэдэг энэ 2 асуудалд маш их санаа зовж байна. Тэгээд улс төрөөс хараат бус байдал дээр хэн аль нь бас байр сууриа илэрхийлэхдээ шүүгч нар өөрсдөө л хараат бус байх ёстой гэсэн. Тэгэхээр ийм механизм ажиллах ямар хэрэг байх вэ гээд олон юмны талаар ярилцах хэрэгтэй байгаа. Тэгээд дөрвүүлэнд нь амжилт хүсье. Тэгээд манай хуульчид ч гэсэн харж байгаа. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний босго өндөр байх ёстой гэдэг дээр бол бас хатуу байр суурьтай байгаа шүү гэдгээ хэлье.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн үгээ хэлье.

С.Эрдэнэболд: Тэгээд сонгогдсон хүмүүс нь болохоор ажлаа хийгээд явах дээр хэдэн санал хэлэх гэсэн юм. Ажил хэрэгч.

1 дүгээрт энэ Шүүхийн ерөнхий зөвлөлийн www.judcouncil.mn гээд веб сайт байгаа. Тэгээд энийг бас тэр та хэдийн өмнөх сонсголын үеэр ярьсан шигээ маш тийм зөв зохион байгуулалттай болгох шаардлагатай байгаад байгаа юм. Тухайлбал энэ дээр жишээлбэл 10 цэс байгаа. 10 цэсийн 10 дахь цэс нь болох юм бол шүүхийн цахимжуулалт гэсэн ийм цэс байгаа. Энэ цэсийн функц бол хангалтгүй байгаад байгаа юм. Жишээлбэл Дээд шүүхийн supremecourt.mn рүү орохоор шүүх хурлын шууд дамжуулалт гээд байгаа. Тэрний архив нь ажиллахгүй байгаа. Дунд шатын юм уу, давахын шүүх хурлууд болж байгаа. Гэхдээ тэд нар яаж байна гэхээрээ дандаа нөгөө нийгмийн сүлжээний сувгаар шууд дамжуулалт явчхаад байгаа. Тийм учраас архив бүрдэхгүй байгаад байгаа. Энэ бол яаж байна гэхээрээ шүүхийн систем өндөр хөгжсөн орнуудад яадаг вэ гэхээр яг үндсэн цахим сандаа дата бэйс үүсгэж явж байгаа. Тэгээд бүр нарийн ярих юм бол бүрэлдэхүүнтэй шийдсэн шүүх хурал дээр яагаад энийг ингэж дэмжсэн, эсэргүүцсэн гэдгээ бүр шүүгч нарийн тайлбарладаг хэсгүүд хүртэл байдаг. Тэгэхээр манайд бол нөгөө цахимжуулалт гэж яриад байгаа боловч илүү нөгөө нийтэд нээлттэй харагдаад байгаа юм шиг боловч яг хууль зүйн салбарын судлаачдад чиглэсэн. Жишээлбэл би 1 жилийн өмнөх шүүх хурлын захиргааны шүүх хурлын бичлэгийг үзье гэвэл олдохгүй. Тэгээд тэнд ямар шийдвэрийг яаж хуулийг эшилснийг үзье гэвэл олдохгүй. Энэ нь эргээд яаж байна гэхээр хуулийн сургуулиудын оюутнуудад цахимаар шууд практик ажил хийх онолын ойлголттой харьцуулж явахад дутагдалтай тал харагдаад байгаа юм. Америк эд нарт бол энийг сайн хийгээд байгаа юм. Энийг ингээд ажил хэрэг болгомоор байна.

2 дугаарт нь болохоор ер нь санаа нь энэ сошиал буюу фэйсбүүк дээр яваад байгаа шууд дамжуулалтууд чинь ямар ч архив үүсэхгүй байна. Тийм учраас фэйсбүүкээс биш яг тэр хамгийн найдвартай дата бэйстэй аюулгүй байдлаа

хангасан цахим дээрээ энэ цахим платформоо уяж явмаар байна л гэдэг саналыг хэлэх гээд байгаа юм.

2 дугаарт judscouncil.mn веб сайт бол албан ёсны хуулийн буюу Шүүхийн ерөнхий зөвлөлийн веб сайт. Энэ дээр хэвлэлийн мэдээний агуулга найруулгатай бичмээргүй байгаа юм мэдээнүүдээ. 2025 оны зүгээр захаас нь 3 сарын 19, 4 сарын 9, 7 сарын 24, 11 сарын 8-нд гарчгийн дүрмийн алдаатай. Би ингээд ямар олон юм нуршаад байлтай биш. Та нар миний хэлж байгаа үгийг харах юм бол ямар ямар алдаа байгааг нь ороод харчхаж болно. Ядаж энэ веб сайт нь өөрөө логикийн алдаагүй байх ёстой. Жишээлбэл саяын 11 сарын 27 дээр гавьяат хуульч төрлөө гэж мэдээ байгаа байхгүй юу. Тэгэхээр энгийн шууд Монгол хэлний дүрмээрээ бол гавьяат хуульч хүн амаржсан юм байна л гэж ойлгогдох байхгүй юу. Тэгтэл тэр чинь албан ёсны биш, энэ чинь хэвлэлийн мэдээний гарчиг тавьчихаж байгаа байхгүй юу. Гавьяат хуульч цолоор шагнагдсан тухай гэдэг шиг яг ингээд би жишээ баримт хэлж байгаа нь цаашлаад энэ нөгөө та нарын яриа дотор байгаад байгаа шүүхийг цахимжуулах, иргэдэд илүү ойлгомжтой, хялбар болгох, цаашлаад хуулийн сургуулийн оюутан, судлаачдад энэ веб сайт нь өөрөө ашиглагдахуун болох ёстой. Тэгээд энийг бас та бүхэн ажилдаа анхаараарай гэж хэлмээр байна.

Уильям Питт гэдэг хүний хэлсэн үг маш олон орны шүүхийн танхимын дээр ингээд бичээтэй байдаг. Ямар үг байдаг вэ гэхээрээ “Хэзээ хууль хэрэгжихээ болино тэр мөчид дарангуйлал тогтоно.” гээд “Where the law ends, tyranny begins.” гэж байгаа. Тэгэхээр яаж байна гэхлээрээ хүмүүсийн хамгийн анхны шударга ёстой тулдаг. Тэгээд дээрээс нь тэр шударга ёсны үнэлэмж мэдэрч авч байгаа зүйл бол угаасаа шүүхийн тогтолцоо шүү дээ. Хурал даргалагч 1 минут нэмээд авчих уу.

Ц.Сандаг-Очир: Эрдэнэболд гишүүн 1 минут.

С.Эрдэнэболд: Тийм учраас энэ сонсголын үеэр хүмүүс энэ сонсгол дээр маш их анхаарч, олон санаа бодлууд хэлж байсан байна гэж би бодож байна. Тэгээд эндээс олонхын дэмжлэг аваад, чуулган руу ороод, цаашлаад сонгогдох байх. Тэр тохиолдолд бас та бүхнийг шударга ажиллаарай гэж хүсье.

Нөгөө талаас өмнөх сонсголын үеэр бас болсон үйлдлүүд бол манай Их Хурлын энэ бас 1 чухал процессын. Тэн дээр 7 байна уу, 70 булчирхайгаа тоочих ёстой. 700 булчирхай ч тоочих шаардлага гарч болно. Юу гэхээрээ парламент өөрөө ингэж ажиллаж байж, парламентын хяналтын механизм өөрөө ингэж ажиллаж байж шударга ёс тогтоох хүмүүст шүүсийг нь шахаж ингэж хандаж байж бид нар эргээд шударга ёсыг шаардах боломжтой л гэсэн үг юм байгаа юм.

Тэгээд сонсголын үеэр зарим нэгэн хүний нэр төр, алдар хүнтэй холбоотой зүйл ярьсан. Тэрийг хувьдаа битгий хүлээж аваарай. Цаашлаад сонгогдсон ч байсан, томилогдоод ажилласан ч байсан, эс томилогдоод ажилласан ч байсан та бүхний хуулийн салбар дахь ажилд нь амжилт хүсье.

Ц.Сандаг-Очир: Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлнэ.

Б.Энхбаяр: Баярлалаа. Дэгээрээ түрүүн нөгөө асуултад хариулах боломж байхгүй учраас би үг байдлаар Сандаг-Очир даргын бас асуултад нэмж хариулъя гэж бодож байна. 2021 онд Шүүхийн тухай хуулийн ажлын хэсгийн ахлагч нь бол би байгаа. Гишүүд нь Сандаг-Очир гишүүн, Алтанхуяг дарга, бид нар хамтдаа хийсэн. Мэдээж бид энэ шүүхийн томилгоо, хариуцлагатай холбоотой асуудал дээр дэвшил

гаргая гэж хэлсэн. Тухайн үед Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг Монгол Улсын Ерөнхийлөгч хэнтэй ч асуулгүй томилчихдог байсан. Бид нар хэн ажиллаж байгааг нь ч мэддэггүй. Ард түмэн байтугай байна шүү дээ Улсын Их Хурлын гишүүд мэддэггүй байсан шүү дээ. Жишээлбэл, манай Алтангэрэл гишүүн гэхэд Шүүхийн ёс зүйн хорооны даргаар ажиллаж байсныг та нар мэдэх үү. Мэдэхгүй байгаа биз дээ. Ажиллаж байсан шүү дээ. Шүүхийн энэ хуульч сонгон шалгаруулдаг Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргаар ер нь хэн ажиллаж байсныг мэдэх үү. Мэддэггүй байхгүй юу.

Тэгэхээр бид нар энэ 1 хүнээс хамааралтай шүүх эрх мэдлийн тогтолцоог илүү олон нээлттэй, илүү процесстой, илүү намтар түүхийг нь гэрэл цохиулдаг, илүү олуулаа шүүдэг ийм тогтолцоог хийхийг л зорьсон юм. Мэдээж төгс төгөлдөр тогтолцоо гэж байхгүй. Гэхдээ нэг юм нь бид өмнө нь 1 хүн хэнд ч мэдэгдэхгүйгээр томилдог байсан энэ асуудлыг парламентаар оруулдаг. Өөрөө өөрсдөө нэр дэвшүүлдэг, намтар түүхээ ухуулдаг. Сая манай Алтанхуяг даргын хэлээд байгаа үгүй ээ, бид нар ч мэдэхгүй байгаа байгаад байна гэж яриад байгаа байхгүй юу. Энэ чинь ажлын хэсгийн 11 хүн санал хураагаад оруулж ирээд байна. Бид мэдэж чадахгүй байна гээд. Үнэхээр бид ч мэдэж болохгүй гэж бодож хийсэн байхгүй юу. Хэрвээ парламентад суудалтай улс төрийн намууд, Улсын Их Хурлын гишүүд шууд нөгөө ажлын хэсэггүйгээр шийддэг болчихвол энэ юу болох вэ гэхээр парламентын намуудын зөвшилцлөөр энэ томилгоо хийгддэг болчих гээд байсан юм. Зөвшилцлөөр. Жишээлбэл одоо байгаа пропорцоор 126 гишүүнтэй парламентад суудал эзэлсэн намаар нь авч үзэх юм бол одоо 4 гишүүний квот яриад байна шүү дээ бид нар. МАН 2-ыг нь тавина. АН-аас 1-ийг нь тавина. ХҮН намаас 1-ийг нь тавина гээд ингээд шийдэх гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ нөгөө улс төрөөс хараат бус байх ёстой шүүх эрх мэдэл гэдэг зарчмаа бид дахиад гажуудуулчих гээд байсан юм.

Тийм учраас ямар ч байсан ард түмний мандаттай 1 гишүүн бол ажлын хэсгээ ахалъя. Тэгэхдээ энэ бол 1 л санал шүү дээ. 1 л санал өөрөө. Өөрөө тэр шийдэхгүй бас. Илүү ийм олуулаа тэгэхдээ нууц санал хураалтаар шийддэг болъё л гэсэн юм. Өмнөх энэ шүүхийн реформын үр дүнд би бол зарим юманд дэвшил гарсан гэж үздэг. Жишээлбэл, Үндсэн хуулийн Цэцийн гишүүнд Улсын дээд шүүхээс 3 хүнийг томилж нэр дэвшүүлдэг. Урьд нь бол Улсын дээд шүүхийн дарга өөрөө бусад шүүгчтэйгээ ч ярилгүйгээр албан бичиг Их Хурал руу явуулаад л Улсын дээд шүүхээс ийм хүнийг томилъё гээд ирүүлдэг байсан байхгүй юу. Тэр үед нөгөө манай хуульчид бас бослого гаргаж байсан юм шүү дээ. Энэ шаардлага хангахгүй хүмүүс Цэц дээр аваачаад байна гээд. Тэгэнгүүт нь бид нар шүүхийн хуулиар юу хийсэн гэхээр Улсын дээд шүүхийн нийт 25 шүүгч хуралдаж байж шийднэ. Тэгэхдээ нууц санал хураалтаар шийднэ. Тэгсэн чинь Монгол Улсын 35 хуульч Улсын дээд шүүхийн босго давж чадаагүй. Улсын дээд шүүхийн 25 хүний босгыг давна гэдэг үнэхээр амаргүй юм байна лээ. Тэндээс ерөөсөө гуравхан хүн босго давсан нь манай салбарын бас тэргүүлэх .../минут дусав/

Ц.Сандаг-Очир: Гүйцээгээд хариулъя. 1 минут.

Б.Энхбаяр: Одоо арай илүү, арай гайгүйг нь л бид нар гаргаж ирдэг тийм процесс руу л явж байгаа юм ер нь бол. Тэрнээс төгс төгөлдөр хүн гэж байхгүй. Төгс төгөлдөр хүн гэдэг бол Бурхан багш, Есүс Христ, Мухаммед Али энэ 3 л байгаа шүү дээ дэлхийд бол. Өөр тийм идеал хүн байна гэж би бол мэдэхгүй. Тунгалаг хүн олох гээгүй, арай гайгүйг нь сонгож олдог бид нар ухаандаа тийм процесс л хийгээд байгаа байхгүй юу. Энэ сарын туршид намтар түүхээ, зам мөрөө ухуулна гэдэг бол

энэ бас хэцүү. Солонгост бол Солонгосын спикер уулзаж байхад хэлж байсан. Манайх энэ нээлттэй сонсголоор бол тухайн манлайлах салбарын ер нь бараг 10 дахь хүн нь л орж ирдэг. Яагаад гэхээр ер нь зам мөрөө ухуулахаасаа айгаад хэр баргийн хүн ер нь нэр дэвшдэггүй гэж хэлж байгаа байхгүй юу. Тэгэхээр нөгөө талдаа энэ хүний нөөцийн чадавхад бас нөлөөлдөг /минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Ганбат гишүүн үгээ хэлье.

Д.Ганбат: Үндсэн хуулиар бол манай шүүх засаглал бол хараат бус байх ёстой. Үүний бас шүүгч нарыг сонгон шалгаруулдаг Шүүхийн ерөнхий зөвлөл 5 гишүүн сонгогддог. Үүний 4-ийг нь бид нар ярьж байна. Мэдээж хэрэг энэ журам, энэ хуулиуд бол бас төгс төгөлдөр биш байна. Тэр нь ойлгомжтой. Засаж залруулах ийм зүйл байна. Өмнөх журам, өмнөх хуулиар явж байсан Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүмжлээд байгаа шүү дээ. Шүүхийн ерөнхий зөвлөлд шүүгч бус гишүүдээс очсон хүнээс дарга дагаад яваад байна гэж байгаа юм. Бүрэн эрх нь дуусаагүй байхад л татаад авчихдаг, больё гээд явчихдаг ийм үйлдлүүд гарч байсан.

Нөгөө талаар манай шүүх өнөөдөр ямар шүүмжлэлтэй учирч байна вэ гэхээр би нийт шүүгчдийг хэлж чадахгүй. Гэхдээ Хөгжлийн банкны сонсгол явсны дараа Хөгжлийн банк 40 тэрбумыг идээд алга болгочихсон ийм нөхөд 40 саяын торгууль аваад, гадаа тэр довжоон дээрээ бие биеийгээ үнсэлцээд л ийм л шийдвэр гаргаад байгаа шүүх шүү дээ. Энд ард нийт, иргэд бол дургүй байгаа. Бухимдаж байгаа. Тэр хонгилыг яаж угсарч байна вэ гэхээр бас арай өөр болчихсон юм билээ. Энэ Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн ерөнхий зөвлөлөөр дамжуулаад угсраад байна уу гэсэн ийм хардлага яваад байгаа. Тэгээд Үндэсний Аюулгүй байдлын зөвлөл нь баахан шүүгчдийг халчхаад буцааж тавьдаггүй. Энэ талаар бол шүүгч нар өөрсдөө дуугарч чадахгүй л дээ. Энэ Шүүхийн ерөнхий зөвлөл дуугарч байх ёстой юм гэх мэтчилэн. Тэгээд шүүмжлэл явж л байна л даа. Энэ 3 давхар байдаг 1 мэргэжилтэй ч юм уу, 1 нөхрийн компьютерт хэнд нь ямар ял өгөхийг бүгдийг нь төлөвлөчихсөн байж байдаг. Яг түүгээрээ болдог гээд л ийм юмнууд яваад байгаа юм. Тэгээд ийм учраас үүнд итгэхгүй болохоор та нар чинь давж заалдах шатны шүүх гэхэд л 6 жил шүүхэд ажиллаж байсан шүүгчээс шалгаруулж байгаа байхгүй юу. Дээд шүүхийн шүүгч гэхэд 10 жил ажиллаж байсан шүүгчээс шалгаруулдаг ийм маш хариуцлагатай ажил хийдэг ийм байгууллага л даа. Тэгэхээр энэ байгууллагад бол хууль зүйн өндөр мэргэшилтэй, мэдлэгтэй, тэгээд ёс суртахуунтай ийм хүмүүс байх ёстой л доо. Тэгээд энийг шалгаруулж байгаа манай Их Хурлын гишүүд ч гэсэн бид нар энэ хүмүүсээсээ ёс суртахуун нэхээд шаардаад байдаг. Бид нар өөрсдөө бас тийм баймаар юм байгаа юм. Мэдээж хэрэг шүүхээр ямар нэгэн гэм бурууг нь тогтоогоогүй бол хэн ч гэм буруутай биш л дээ. Гэхдээ асуудал нь хууль хяналтын байгууллагаар явж байгаа, яллагдагчаар татагдсан ч байдаг юм уу ийм хүмүүс саналаараа энэ Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгч нарыг шалгаруулдаг энэ байгууллагыг сонгон шалгаруулах энэ юманд нь бол оролцдоггүй баймаар байгаа юм. Би больчихъё гээд. Ингэж л үлгэр жишээ үзүүлж ингэж явж байвал энэ улс орон чинь энэ хууль тогтоох байгууллагад итгэх итгэл чинь, энэ шүүгч нарт, Шүүхийн ерөнхий зөвлөл шалгаруулах энэ зүйлд чинь итгэл үнэмшил нь арай бий болж эхлэх юм. Тэгээд мэдээж хэрэг ардчилал гэдэг чинь цаг хугацаа шаарддаг ийм зүйл л дээ. Иргэд ч гэсэн эндээ бэлтгэгдэж байгаа байх. Жилээс жилд өөрчлөгдөж байгаа байх. Тэр лүү шударга ёс руу энэ бүх юм руу алхам алхмаар ойртож байгаа байх гэдэгт бол итгэж найдаж байна.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Би бас ганц нэг санал хэлье. Асуусан асуулттайгаа холбогдуулж. Өнөөдөр ингээд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус

гишүүний 4 гишүүнийг сонгож байна. Түрүүн би асуултдаа өмнөх 4 гишүүн ер нь хэр сайн ажилласан бэ. Юу гэж дүгнэж байгаа вэ гэсэн хариулах хүн олдохгүй л байна л даа. Ер нь цаашдаа бид нар Хууль зүйн байнгын хороо, Улсын Их Хурлаас томилогддог төрийн өндөр албан тушаалтнуудын ажил хүлээлцэх процесс, энэ ажил хүлээлцэж байгаа үеийн асуудлыг бас яримаар байгаа юм. Тухайн албан тушаалд 6 жил, 4 жил ажиллалаа гээд та ер нь ямар ажил хийсэн бэ. Ямар ахиц дэвшил, өөрчлөлт гаргасан юм бэ гэдэг юмыг нь сонсож байж. Тэгэхгүй зүгээр 1 сайд очоод л Монголбанкны захирлыг хүлээлцүүлчихдэг. Прокуророор очоод л ажлыг нь хүлээлцүүлчихдэг. Тэгээд яг юу хийсэн юм гэдгийг нь ерөөсөө ингээд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус 4 гишүүн өнөөдөр ингээд орон тооны 4 хүмүүс томилогдох гэж байна. Өнгөрсөн 4 жилийн хугацаанд энэ 4 хүн юу хийв гэдэг асуудлыг бас бид нар Шүүхийн тухай хуульдаа томилох асуудлыг нь л аягүй сайн яриад байдаг. Буух гэж байгаа үеийнх нь процесс нь ерөөсөө энэ хуульд огт тусгаагүй орхигдуулчихсан. Юу хийсэн юм. Тэгээд л тэр 4 ингээд сонгогдоод, 4 жил ажиллаад л ингээд яваад өгдөг. Тийм учраас бид нар бас энэ хуульдаа сая Алтанхуяг гишүүн ярьж байна. Хуульд бас засаж залруулах юмнууд байгаа гэдэгтэй адилхан санал нэг байна. Бас энэ асуудлыг бас хөндөж цаашдаа бас хуульд энэ талаар оруулж өгөх ёстой юм байна лээ шүү. Тийм учраас энэ төрийн өндөр албан тушаалтнууд эндээс хариуцлага харагдана. Зөвхөн 2 албан тушаалтан ажлаа хүлээлцэж байгаа юм шиг боловч үүний цаана асар том мэдээ, мэдээллийн асуудлууд байна. Ажлаа хэрхэн яаж хүлээлцэж байгаа юм, хүлээлцэх юм. Тэр процесс зүгээр ингээд тамга тэмдэг солилцсоноор төрийн өндөр албан тушаалтнуудыг ингээд ажил хүлээлцүүлээд баймааргүй байна. Тэр тооцоо судалгаа юмнууд нь юу байна гээд ингээд бүх юмнууд дээр нь ажлыг нь ингэж албан ёсоор төрийн ажил шүү дээ энэ чинь. Төрийн ажил хүлээлцэж байгаа. Тийм учраас тэр болгоныг хуульд тусгаж ингэж нарийвчилж өгөх хэрэгцээ шаардлага байгаа юм байна гэдгийг бас дараа дараагийн хууль дээрээ бас анзаарч засаж залруулах ёстой юм байна гэдгийг энэ бол Сайнзориг гишүүн бид 2-ын бас санал гэдгийг бас протоколд тусгуулъя гэж бодож байна.

Ингээд гишүүд Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнийг сонгон шалгаруулсан ажлын тайлан болоод нэр дэвшигчдээс асуулт асуухж, үг хэлж дууслаа.

Одоо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.4 дэх хэсэгт Хууль зүйн байнгын хороо хуульд заасны дагуу санал болгосон нэр дэвшигч нэг бүрээр санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар нэр дэвшүүлэхийг дэмжсэнд тооцно гэж заасны дагуу санал хураалт явуулна. Баасанжаргал гишүүн горимын санал гаргаж байна. Баасанжаргал гишүүний микрофон.

Х.Баасанжаргал: Санал хураалттай холбоотой горимын санал гаргаж байна. Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 10.1-д заасны дагуу санал хураалтыг илээр явуулна. Тухайн хуралдаанд оролцож байгаа гишүүдийн олонх зөвшөөрөх юм бол санал хураалтыг нууцаар явуулна гэж байгаа. Тийм учраас би энэ санал хураалтыг нууцаар явуулж өгөөч ээ. Хувь хүмүүсийн асуудлыг бид нар шийдвэрлэх гэж байгаа учраас энэ санал хураалт нууцаар байх нь зүй ёсонд нийцнэ гэж үзэж байна. Тэгэхээр гишүүдийгээ нууцаар, цахимаар гэдэг төрөл. Нууцаар, цахимаар явуулж өгөөч. Тэгээд гишүүдийг бас энийг дэмжээч ээ гэж хүсэж байна. Нууцаар цахимаар.

Ц.Сандаг-Очир: Цахимаар гэсэн үг. Тэгэхдээ нууцаар гэж байх шиг байна. Тэр технологи юу нь байгаа юу. Болох уу. Алтанхуяг гишүүн Баасанжаргал гишүүний гаргасан горимын саналтай холбогдуулж санал хэлье гэнэ. Алтанхуяг гишүүний микрофоныг өгчихье.

Н.Алтанхуяг: Эрхэм гишүүд ээ, хуулиараа бол ингээд бид нар олонхоороо хаалттай явуулъя гээд явуулчхаж болох л байх л даа. Саналаа хураагаад шийднэ шүү дээ. Зүгээр надад жаахан тийм онцгүй санагдаж байна шүү. Яах гэж ер нь надаар та нар сонсгол удирдуулсан юм. Би бас нэг юм хэлж удирдсан шүү. Би хийхгүй гэсэн. Гэтэл шударга бус юм байвал олон нийтэд ил гарга гэж хэлээд нисэхгүй нисэхгүй гээд байсан нис нис гээд намайг тэнд суулгасан даа. Одоо тэгчхээд та нар олон нийтийн өмнө ер нь сонсголоо сайхан ил тод явуулчхаад, одоо нууцаар санал хурааа гэвэл их онцгүй. Жишээ нь Монгол Улсын Ерөнхий сайд байсан Алтанхуягийг огцруулах саналыг илээр хураадаг байхгүй юу бид нар. Бас нууцаар хураахад таны хэлж байгаа шиг хувь хүний асуудал гээд бид нар их олон юм тайлбарладаг. Гэхдээ аймар их хуйвалдаан явдаг. Дараа нь тэгээд хэн тэгсэн, ингэсэн гээд. Би бол илээр саналаа өгмөөр байна. Яагаад гэхээр би ингэж бодоод, үүний төлөө дэмжсэн, би ингэж бодоод энэ хүнийг дэмжээгүй гэдэг юмаа тайлбарлан ярих тийм боломж олгохгүй юм уу. Наадах чинь их олон хүмүүс их л таагүй хүлээж авна даа. Үгүй ээ, үгүй харин би нөгөө олонхоороо шийдчихээр гарах үр дагаврыг чинь би хэлэх гэж байна шүү л гэж байна.

Ц.Сандаг-Очир: Би ч гэсэн Алтанхуяг гишүүнтэй санал нэг байна. Нууц юм болгоны цаана хуйвалдаан байдаг. Аль болохоор бид нар ил тод, нээлттэй, хэн ямар байр суурь илэрхийлж байгаагаа л яах гээд байгаа. Одоо гишүүд ээ Баасанжаргал гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Баасанжаргал гишүүний горимын санал дэмжигдвэл санал хураалтыг нууцаар явуулах технологийн юу байгаа. Боломжтой. Дэмжигдэхгүй бол илээр санал хураалтаа явуулна гэсэн үг. Ингээд санал хураалтад бэлдье гишүүд ээ.

Нэр дэвшигчтэй холбоотой санал хураалтыг нууцаар, цахимаар явуулъя гэсэн Баасанжаргал гишүүний гаргасан горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 15 гишүүнээс 5 гишүүн дэмжиж, 33,3 хувиар Баасанжаргал гишүүний гаргасан горимын санал дэмжигдээгүй учраас нэр дэвшигчдийг нэр дэвшигч тус бүрээр ил санал хураалтаар явуулна. Санал хураалтдаа бэлдээрэй. Санал хураалт.

Хүрэлбаатарын Эрдэм-Ундрахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтыг цуцалъя. Би сая санал хураалтдаа бэлдье гэж хэлсэн шүү дээ. Энэ санал хураалтыг цуцалъя. Одоо дахиад санал хураалтдаа бэлдье. Дахиад санал хураалтдаа бэлдье гэж зарлах уу. Бид нарынх орсон юм уу. Орчихсон байна. 15 гишүүн бэлтгэгдсэн байна. Хураалаа шүү. Ороогүй байна уу. Оруулчих. Саналын томъёоллыг уншсан.

1. Хүрэлбаатарын Эрдэм-Ундрахыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 15 гишүүнээс 15 гишүүн дэмжиж, 100 хувийн саналаар дэмжигдлээ.

2. Чадраабалын Баянжаргалыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 15 гишүүнээс 11 гишүүн дэмжиж, 73,3 хувиар санал дэмжигдлээ.

3.Цэнд-Аюушийн Жавхлантөгсийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 15 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 46,7 хувиар дэмжигдсэнгүй.

4.Чинзоригийн Өнөржаргалыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 15 гишүүнээс 6 гишүүн дэмжиж, 40 хувиар санал дэмжигдсэнгүй.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүнд нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцэж дууслаа.

Дэмжигдсэн 2 гишүүнийг Улсын Их Хурлын нэгдсэн чуулган руу оруулж танилцуулна.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ. Баярмаа гишүүн танилцуулъя. 1 дэх асуудал хэлэлцэж дууслаа.

16.27 цаг.

Дараагийн асуудалдаа орёе. 2 дахь асуудал. Хөөе гишүүд ээ, одоо 1 асуудал үлдсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийг хэлэлцье.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс Улсын Их Хуралд 2025 оны 12 дугаар сарын хэдний өдөр юм бэ дээ. Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийг ирүүлсэн. Цэцийн дүгнэлтийг гишүүдэд тараасан байгаа. Үндсэн хуулийн цэцийн 10 дугаар дүгнэлтийн талаар товч танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, итгэмжлэн төлөөлөгч Баттөмөрийн Энхбаяр хийнэ. Энхбаяр даргыг микрофон дээр урьж байна.

Б.Энхбаяр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаан 2025 оны 11 дүгээр сарын 24, 25-ны өдөр Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд болсон бөгөөд хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Баясгалан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Өлзийсайхан, Гангабаатар, Мөнхсайхан, Батрагчаа нарын бүрэлдэхүүнтэйгээр хуралдсан.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн Баттуул, түүний өмгөөлөгч Оросоо, мэдээлэл гаргагч иргэн Номынбаясгалан, түүний өмгөөлөгч Тамир, мэдээлэл гаргагч иргэн Галбаатар, Сумъяабазар, Чанцалдулам, Энэрэл, Анхзаяа, Хүрэлбаатар, шинжээчээр Хууль зүйн ухааны доктор, профессор Солонго, хууль зүйн ухааны доктор, дэд профессор Тэмүүлэн, сэтгүүлч Боргилмаа нар оролцсон бол Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр миний бие оролцсон.

Энэхүү хуралдаанаар дээр дурдсан нэр бүхий Монгол Улсын иргэдээс Үндсэн хуулийн цэцэд хандан ирүүлсэн мэдээлэл буюу Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр

зүйлд “хүний нэр төр, алдар хүн, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол 450 нэгжээс 1300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 240 цагаас 720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 1 сараас 3 сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн эрх чөлөө, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн. 16 дугаар зүйлийн 16 дахь заалтын “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй.” Мөн зүйлийн 17 дахь заалтын “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй.” 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” 70 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг тус тус зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцсэн.

Мэдээлэл гаргагч нь дараах агуулга бүхий мэдээллийг Цэцэд гаргасан. Үүнд:

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл. Худал мэдээлэл тараах гэсэн зүйлийг нэмэлтээр оруулсан нь Иргэний хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэгдэж болох иргэний гэм хорын асуудлыг гэмт хэрэгт тооцсон нийгэмд нэгэнт тогтсон ойлголт уу эсхүл зохиомол бий болгосон ойлголт уу гэдгээс үл хамааран аливаа хэлбэрээр үзэл бодлоо илэрхийлэх, чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөний агуулгыг үндэсний эрх зүйн тогтолцоонд явцуу хязгаарлагдмал байдлаар авч үзэх нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ Монгол Улсын Үндсэн хууль төдийгүй Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын гэрээнд тодорхойлсон иргэний үндсэн эрхийг хязгаарлаж болох зохих суурь стандартад нийцэхгүй байна.

Хүн итгэл үнэмшил, үзэл бодолтой байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эрх чөлөөгөө хэрэгжүүлэх суурь нөхцөл нь мэдээлэл хайх, олж авах эрх юм. Олон улсын эрх зүйгээс ялгаатай нь Монгол Улсын Үндсэн хуульд мэдээлэл хайх, хүлээн авах эрх чөлөөг үзэл бодолтой байх, илэрхийлэх эрх чөлөөнөөс тусад нь бие даасан үндсэн эрх болгож баталгаажуулсан онцлогтой. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн эрх чөлөө нь мэдээлэл хайх, хүлээн авах үндсэн эрхийг нөхцөлдүүлдэг тул тус эрх чөлөө зөрчигдсөн тохиолдолд мэдээлэл хайх хүлээн авах эрх зөрчигдөх боломжтой. Худал мэдээлэл тараах тухай хуулийн хатуу хариуцлага нь олон нийтийн өмнөөс шүүмжийг өрнүүлдэг сэтгүүлч, нийгмийн идэвхтнүүд, олон дагагчтай фэйсбүүк хэрэглэгч нар амандаа үдээр хийх буюу өөрийн цензурт түлхэх, улмаар тэд дуугарахаас татгалзаж эхэлдэг. Үр дагавар нь ардчилал нээлттэй, ил тод байдалд асар сөргөөр нөлөөлдөг гэжээ.

Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Энхбаяр миний бие Үндсэн хуулийн цэцэд хандан холбогдох тайлбарыг бэлтгэн өөрийн биеэр оролцсон. Цэцийн дүгнэлтийн дүгнэлт хэсэгт миний тайлбар бүрэн байгаа.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн үндэслэл нь дараах агуулгатай байна.

1. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16, 17 дахь заалтад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө нь ардчилсан нийгмийн суурь, үнэт зүйл болохыг өргөн агуулгаар баталгаажуулжээ. Энэхүү эрх чөлөө нь итгэл үнэмшил, үзэл бодолтой байх, түүнийгээ үг хэлэх, хэвлэн нийтлэх болон бусад хэлбэрээр чөлөөтэй

илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх зэрэг харилцан хамаарал бүхий цогц эрхийг өөртөө багтааж байна. Итгэл үнэмшил, үзэл бодолтой байх эрх чөлөө нь хувь хүний дотоод мөн чанарыг хамгаалдаг туйлын эрх тул түүнийг ямар ч тохиолдолд хязгаарлаж болохгүй.

Харин итгэл үнэмшил, үзэл бодлыг илэрхийлэх нь гадагш чиглэсэн нийтэд хамаатай тул ийнхүү илэрхийлэх эрх чөлөөнд Үндсэн хуульд заасан зарчим, шаардлагын дагуу хязгаарлалт тогтоох боломжтой. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь заалтын халдашгүй чөлөөтэй байх эрхийн хүрээнд хүний нэр төр, алдар хүндийг хамгаална. Хүний нэр төр бол хүн болж төрсөн хэн бүхэнд угаас заяасан адил үнэ цэн бөгөөд туйлын эрхэд тооцогдоно. Алдар хүнд бол хувь хүний нийгэмд эзлэх байр суурийг илэрхийлэх гадаад үнэлэмж бөгөөд түүнд хууль бусаар халдахыг Үндсэн хуулиар хориглоно. Иймд Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл нь илт худал мэдээлэл тараахыг хориглох замаар хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд хууль бусаар халдахаас хамгаалахад чиглэсэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх чөлөөнд тогтоосон хязгаарлалт мөн байна.

2. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалт нь үндсэн эрхийн хязгаарлалт тавих нийтлэг шаардлага болон тухайн эрх чөлөөний мөн чанараас үүдсэн тусгай шаардлагыг давхар хангах ёстой. Эдгээр шаардлагын аль нэгийг хангаагүй нь үндсэн эрхийг зөрчсөн гэх үндэслэл болно. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл нь эрх зүйн тодорхой байдалд тохирсон байх зарчим гэсэн нийтлэг шаардлагыг хангаагүй байна.

3. Хүний алдар хүндийг хамгаалах зорилгоор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлах хуулийн зохицуулалт нь эдгээр үндсэн эрх хоорондын тэнцвэрийг хангах, Эрүүгийн хуулиар хязгаарлах тохиолдолд түүний хүрээг ноцтой түвшинд явцууруулан тодорхойлох болон нэмэлт эрхийн шалгуур зэрэг тусгай шаардлагыг хангах ёстой. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл энэхүү тусгай шаардлагыг хангаагүй байна.

4. Дээрхийг бүхэлд нь дүгнэж үзвэл маргаан бүхий зохицуулалт нь үндсэн эрхийн хязгаарлалтад тавих нийтлэг шаардлага болон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалтад тавих тусгай шаардлагыг хангаагүй байна. Иймд Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл нь Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан эрх чөлөөний болон хууль дээдлэх зарчмыг, 16 дугаар зүйлийн 16.17 дахь заалтаар хамгаалсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө, мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрхийг тус тус зөрчиж, улмаар 70 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн Үндсэн хуульд хууль бүрнээ нийцсэн байх зарчмыг алдагдуулсан байна.

5. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлээр худал мэдээлэл тараахыг гэмт хэрэгт тооцсон нь үзэл бодол, итгэл үнэмшилд бус харин түүний илэрхийлэлд тавьсан хязгаарлалт байх тул Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь заалтын итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг хөндөөгүй байна.

6. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлээр хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараахыг хориглосон нь эдгээр эрх, ашиг сонирхлыг хамгаалах хууль зүйн баталгааг бүрдүүлэхэд үйлчилж байх тул Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна гэсэн дүгнэлтийг гаргажээ.

Цэцийн дүгнэлт болохоор бас хариуцлагатай. Ингээд Үндсэн хуулийн цэцээс дараах дүгнэлтийг Үндсэн хуулийн нэрийн өмнөөс гаргасан байна.

1 дүгээрт Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол 450 нэгжээс 1300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 240 цагаас 720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 1 сараас 3 сар хүртэл хугацаагаар зорчихыг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн эрх чөлөө хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, 16 дугаар зүйлийн 16 дахь заалтын “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй.” Мөн зүйлийн 17 дахь заалтын “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл авах, хүлээн авах эрхтэй.” 70 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16 дахь заалтын “итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөтэй.” 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасныг зөрчөөгүй байна.

3. Эрүүгийн хуулийн 13.14 дэх зүйлд “хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол 450 нэгжээс 1300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 240 цагаас 720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 1 сараас 3 сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж заасныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай гэжээ.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Цэцийн дүгнэлтийн товч танилцуулгыг хийж дууслаа. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Баярмаа гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүн, Уянгахишиг гишүүнээр тасаллаа. Сайнзориг гишүүн асуултаа асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Энхбаяр сайдаас л асууя даа. Итгэмжилсэн төлөөлөгчөөр орсон байна. Ерөнхийдөө энэ Үндсэн хуулиар хамгаалагдсан 1 эрхийг нөгөө эрхээс дээгүүр тавих гэдэг юм уу, илүүд үзэх энэ зүйл явчхав уу гэж зүгээр энгийн үгээр хэлмээр байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол бас энэ асуудлын цаад талын үр дагавар бол нийгэмд ноцтой болно шүү. Хүнийг үзэл бодлоо илэрхийлэх

энэ эрх чөлөөг нь ерөөсөө хязгаарлах гээд байгаа зүйл байхгүй. Монголд бол байгаа. Харин үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх эрх чөлөө гэдэг бол худал мэдээлэл тараах хэн нэгнийг гүжирдэх, гүтгэх гэдгээс тэнгэр газар шиг ялгаатай байхгүй юу.

Тийм ч учраас сэтгүүл зүйд хардах гэхээсээ илүүтэй нотолгоо баримтад суурилсан эрэн сурвалжлах сэтгүүл зүй гэж байдаг. Энэ дээрээ л суурилж юмаа явах ёстой. Хэт бас ингээд манай сэтгүүлчид маань энэ рүү л ингээд явчих шиг боллоо. Би зүгээр үүний үр дагаврыг Хууль зүй, дотоод хэргийн ийн сайд юу гэж харж байгаа вэ. Энгийг та бас нэг товчхон хэлж өгөөч.

2 дугаарт, ер нь энэ Эрүүгийн хуулиар хүний нэр төр алдар хүндийг хамгаалдаггүй хэчнээн орон байдаг юм бэ. Хамгаалдаг хэд байдаг юм бэ. Энэ талын судалгаа бол бас хийгдэж байсан. Хамгийн сүүлийн байдлаар ямархуу мэдээлэл байна. Та бас олон нийтэд хэлж өгөөч.

2 дугаарт энэ цахим орчинд нэр хаяггүй, нөгөө хиймэл оюун AI, энүүгээр чинь баахан янз бүрийн юм зохиогоод цацаад байхад жирийн иргэн хүн хууль сахиулах байгууллагын оролцоогүйгээр тэр компьютерын цаана байгаа хүнийг олж чадах болов уу. Тэгээд иргэний шүүхээр яваад нэр төр, алдар хүндээ сэргээлгэх тэр боломж нь гарах болов уу. Энгийг та бас юу гэж харж байгаа вэ. Ийм 3 асуултыг бас асууя гэж бодож байна.

Ц.Сандаг-Очир: Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Үндсэн хуулийн цэц 30 гаруй жилийн хугацаандаа Эрүүгийн хуулийн тодорхой төрлийн гэмт хэрэг Үндсэн хууль зөрчсөн гэж шийдвэр гаргасан анхны тохиолдол бол энэ болж байгаа. Түүгээрээ Үндсэн хуулийн шинжлэх ухаанд ч тэр, эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд ч тэр энэ бол том судлагдахуун болох ийм асуудал болсон. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч яг таны хөндөж байгаа энэ байр суурийг бас нотолж, цэцийн хуралдаанд оролцсоныг та Цэцэд хүргүүлсэн миний тайлбараас бас харж болно. Энэ Цэцийн хуралдаанд тухайлбал, миний бие бусад улс орны Эрүүгийн хууль тогтоомжид энэ гүтгэх асуудал ер нь хуульчлагдсан байдаг уу гэдэг харьцуулсан судалгааг Цэцэд бол өгсөн байдаг. Энэ ардчилсан гэж байгаа, хүний эрх гэж байгаа бүх улсад энэ асуудал Эрүүгийн хууль тогтоомжоор хүний нэр, төр алдар хүнд Эрүүгийн хуулиар хамгаалагддаг. Эрүүгийн хуулиар хамгаалагдана. Тэр дотроо энийг сая гарсан Эрдэм-Ундрах доктор ахалж хийсэн судалгаа байгаа байхгүй юу. Энэ 2023 оны 11 сарын 27-ны өдөр. Энэ судалгааг аваад үзэхэд бидний эх газрын тогтолцооны загвар болгодог Франц, Герман улсууд хорих ялтай байгаа. Хамгийн ардчилсан, бага шийтгэлтэй гэгддэг байдаг Норвег гэхэд 12 мянган еврогийн шийтгэлтэй байгаа. Гүтгэх гэмт хэрэг дээр. Манай улс бол Эрүүгийн хууль тогтоомждоо хорих ял байхгүй. Сая хэлж байгаа 450 мянгаас 1 сая 300 мянган төгрөгөөр торгох шийтгэлтэй.

Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт бол энэ гэмт хэрэг дээр хорих ял ноогдуулж болохгүй гэж байгаа юм. Бүр зорчих эрх хязгаарлах ял ноогдуулж болохгүй. Торгох ял байж болно. Тэгэхдээ боломжит бага хэмжээндээ байна шүү гэж байгаа юм. Боломжит бага хэмжээндээ байгаарай гэж байгаа юм. Цэцийн шийдвэрт тийм өгүүлбэр байгаа байхгүй юу. Хэрэв торгуулийг чинь нэмэх юм бол дахиад Үндсэн хууль зөрчсөн шүү гэж үзнэ гэж хэлж байх шиг байгаа юм. Би бол Цэцийн шийдвэрээс. Тийм учраас Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг бол нэлээн нухацтай авч үзэх ёстой. Таны хэлж байгаа болгоомжлол бол үнэн. Үндсэн хууль болон

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактаар хүний нэр төр, алдар хүндийг хамгаалах хүрээнд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх эрх чөлөөнд хязгаарлалт тавьж болно гэж байгаа. Манай Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд. Одоо энэ цэцийн дүгнэлтийн дагуу Монгол Улс гүтгэсэн үйлдэлд энийг шалгах бололцоогүй болчихоод байгаа /минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Сайнзориг гишүүн тодруулга 1 минут.

П.Сайнзориг: Болж өгвөл Энхбаяр сайдад дахиад 1 минут. Би бол зүгээр иргэд, олон нийт энэ бодит мэдээллийг аваасай л гэж байгаа юм. Одоо энийг ингээд зарчмын хувьд ярьчихаар нэг л их баахан хүмүүсийг барьж хорьж, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхаж байгаа юм шиг ингээд улс төр хийгээд, буруу тийшээ бужигнаад байна. Энэ явж явж жирийн иргэд л хохирно. Саяхан өглөө надтай 1 сэтгүүлч таарсан. 1 сумын дотоод фэйсбүүк чат байдаг юм байна. Сумынхан ордог. Тэн дээр 1 сувилагч эмэгтэйг маш эвгүйгээр бичээд, нөгөө сувилагч эмэгтэй бараг амиа хорлох дээрээ дөхөж байна гэж байна. Ийм л юм газар авна. Хуулийн этгээдүүд бие болж зүй бус өрсөлдөөн буюу яг бизнес зарчмаар биш бие биеийнхээ эсрэг худал мэдээлэл тарааж, энэ бизнесүүдээ унагаадаг болно. Компьютерын араас нэр, хаяггүй хүмүүс, троллууд жирийн иргэдийг зүгээр зохиож гүтгэж янз бүрийн юм эвлүүлж тавина. Тэгээд энийг иргэний шугамаар явах бололцоотой гэж байгаа боловч иргэн дээр чинь нэхэмжлэлээ гарахад цаана нь хэн байсан бэ. Энэ үйлдлийг хэн хийсэн бэ гэдэг дугаар хорооны иргэнийхээ хаягийг өгдөг байхгүй юу. Энийг олж /минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Сүүлийн 1 минут Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Тэгээд яах вэ, би зүгээр цэцийн энэ шийдвэр дээр хорих ял оногдуулахгүй энэ тэрийг бол дэмжээд байгаа шүү дээ. Энэ анхнаасаа ч хорих ял байгаагүй. Тэгэхдээ ийм эрүүгийн эрх зүйн ямар үйлдэл, эс үйлдлийг гэмт хэрэгт тооцох уу, үгүй юу гэдэг рүү Цэц орж, хазайж орно гэдэг бол бас л шинэ жишиг боллоо. Одоо тэгээд энэ дээр хэдүүлээ бас л ярилцах ёстой юм байна. Тэгээд явж явж уг нь Хэвлэлийн эрх чөлөөний хуулиа бид нар сайжруулах ёстой юм. Мэргэжлийн редакцтай, өөрийгөө хэвлэл мэдээллийн байгууллага гэж байгаа энэ хүмүүсийн асуудлыг тэр хэвлэлийн арбитраар нь эсвэл Хэвлэлийн ёс зүйн зөвлөлөөр нь магадгүй хэвлэлийн омбудсмен гэж байдаг хэвлэлийн комиссарууд буюу энэ олон төрөлт байдлуудаар маргааныг нь шийддэг зөвтгөдөг ийм зүйлүүд уг нь байж болох байсан. Тэгээд цаана нь жирийн иргэд бие биеэ яагаад энэ их л үр дагаврыг нь дараа нь хэн хариуцах юм бол доо. Цэц хариуцах болов уу. Баахан хүмүүс амиа хорлох түвшинд хүрээд ирэхээр яах бол. Энэ дээр бас цаашдаа яах ёстой вэ. Хууль зүй, дотоод хэргийн сайд бас зөрчил рүү оруулах /минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Энхбаяр сайд.

Б.Энхбаяр: Мэдээж хүний үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг төр хамгаалах үүрэгтэй. Энийг далимдуулаад мангасдаад байна. Зарим улс төрийн нөхөд энийг ашиглаад, үзэл бодлыг шоронжуулах гээд байна. Айлгах гээд, ичээх гээд байна гэдэг ийм үндэслэлээр энэ асуудал Үндсэн хуулийн цэцэд маргаан очсон. Энэ хүрээндээ хууль тогтоогч бол Эрүүгийн хуулийн 13.14-ийг боловсронгуй болгох, өөрөөр хэлбэл тэр илт худал мэдээлэл гэдэг мэргэжлийн алдаа, андуурал энэ юмнуудаас нь ялгаж, зориуд санаатай зохион байгуулалттайгаар гүтгэж байгаа үйлдлийг нь бол хариуцлагатай байлгах ёстой гэдэг талаас нь бол хэлсэн. Тэгтэл ингээд давуулаад бүхэлдээ Үндсэн хууль зөрчсөн гээд хүчингүй болгосны гор нь юу

болж гарах гээд байна вэ гэхээр энэ нийгмийн ёс суртахууныг эвдэж байгаа, хүн хүнээ гүтгэж байгаа энэ үйлдэл ямар ч хариуцлагагүй болчхоод байгаа юм.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: 1 минут гүйцээгээд хариулъя.

Б.Энхбаяр: Сайнзориг гишүүн чухал ньуанс хөндөөд байгаа байхгүй юу. Энэ Эрүүгийн хуулиас энэ заалт 11 сарын 24-ний өдрөөс ингээд түдгэлзсэнээс улбаалаад юу болоод байна вэ гэхээр энэ гүтгэлгийн чинь 90 гаруй хувь нь цахим орчинд яваад байгаа юм. Тэр дотроо нэр нүүрээ нуусан хаягуудаас яваад байгаа юм. Зохион байгуулалттай. Энийг иргэний шүүх олж тогтоодоггүй. Зөвхөн Мөрдөх алба тэр цаад эзнийг нь энэ хаягийн ард ямар нэр нүүрээ нуусан этгээд байгааг мөрдөх байгууллага олж тогтоодог байхгүй юу. Тэгэхээр энэ нэр нүүрээ нуусан цахим хаягийн цаана гүтгэлэг доромжлолыг түгээж байгаа энэ этгээдүүд ямар ч хариуцлагагүй ийм нийгэм рүү бид явлаа шүү. Үүний хариуцлагыг хэн үүрэх, хэн үүрэхгүй тухай би одоо хэлэх юм алга. Тэгэхдээ энэ мэдээж удаан явахгүй. Яагаад вэ гэхээр нийгмийн ёс суртахууныг хамгаалах чинь төрийн үндсэн үүрэг шүү дээ бас. /минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Уянгахишиг гишүүн асуултаа асууя.

Г.Уянгахишиг: Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбоотойгоор 1 зүйл тодруулж асууя. Өөрөөр хэлэх юм бол итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд энэ цэцийн дүгнэлтийн үндэслэх хэсэгт дурдсан асуудлуудаар буюу тухайн хуулийн заалтын зохицуулалтыг сайжруулах ёстой, илүү нарийвчлах ёстой гэж харж байгаа буюу бид нар энэ цэцийн дүгнэлтийг хүлээж аваад, тэр хуулийнхаа заалтыг засах ёстой гэж үзэж байна уу гэдэг асуултыг асуух гээд байгаа.

Үүнтэй холбоотойгоор яг энэ үндэслэх хэсгийн 1 хэсгийг уншмаар байна л даа. Энэ дээр бол ингэж байгаа юм. Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйл тусгай шаардлагыг нэмэлт эрхийн шалгуур зэрэг тусгай шаардлагыг хангах ёстой. Тэгэхээр энэ тусгай шаардлагыг хангаагүй байна гээд энэ дээр юу гэсэн бэ гэхээр маргаан бүхий зохицуулалт нь хүний алдар хүнд, халдашгүй байх эрх болон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө хоорондын тэнцвэрийг хангаагүй байна.

Нэгд, нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудлаар үзэл бодлоо илэрхийлснийг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болон хэвлэн нийтлэх эрх чөлөөний дагуу бусад төрлийн илэрхийллээс илүү хамгаалах зохицуулалтыг хуульчлаагүй байна.

2-т, нийтийн зүтгэлтэн өөрийнхөө эсрэг шүүмжийг иргэнээс илүү хүлцэн тэвчих эрх зүйн зохицуулалтыг бий болгоогүй байна.

3-д, үйл баримтын шинжтэй мэдээлэл болон үнэлэлт дүгнэлтийг ялгаж зохицуулаагүйгээс үйл баримтын шинжтэй мэдээллийг үндэслэн илэрхийлсэн үнэлэлт дүгнэлтэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрсдэлтэй байна.

4-т, мэргэжлийн ёс зүйтэй сэтгүүл зүйг тусгайлан хамгаалаагүй тул нийтийн ашиг сонирхолтой холбоотой үйл баримтыг үнэнч шударгаар мэдээлэх явцад гарсан мэргэжлийн алдаанд ял шийтгэх боломжтой байна гэж байгаа юм.

Тэгэхээр эдгээр зохицуулалтын гол юу нь юу байна вэ гэхээр жишээлэх юм бол яг одоо гүтгэгдсэн ч гэдэг юм уу, илт худал мэдээлэл тараагдсан, алдар хүндэд нөлөөлсөн гэдэг дээр жишээлбэл, Герман улсад яадаг вэ гэхээр олон нийтийн танил буюу ялангуяа улс төрчдийн хувьд хүлцэн тэвчих нөхцөл нь илүү өндрөөр тавигддаг. Яагаад гэвэл нэгэнт өөрсдийнхөө нэр төр, алдар хүндийг олны өмнө гаргаад тавьчихсан учраас тодорхой хэмжээнд тэр өөр лүү нь дайрсан мэдээллүүдийг хүлээж авах ёстой гэдэг ийм үндсэн зарчим яваад байдаг л даа. Тэгэхээр энэ талаасаа бид нар яг энэ тухайлсан хуулийг яг ямар тохиолдолд илт худал мэдээлэл, илт худал мэдээлэл гэдэг бол жишээлбэл хүний овог нэрийг овгийн жишээлбэл буруу хэлчихлээ гэхэд илт худал мэдээлэл гэвэл үнэн үү гэвэл үнэн шүү дээ. Тэгээд жишээлбэл юу гэдэг юм тэдэн удаа, эдэн удаа гэдэг мэдээллүүд байдаг. Тэгэнгүүт тэр нь яг үйл баримтын хувьд бол айхтар ялгаатай биш ч гэсэн 20 удаа гэдгийг, 22 удаа томилолтоор явсан ч гэдэг юм уу хэлчихлээ гэхэд тэр 2-ын зөрүү дээр энэ чинь илт худал мэдээлэл гэвэл илт худал мэдээлэл.

Гэхдээ энэ мэргэжлийн алдаа гаргаад гэдэг юм уу, санаатайгаар илт гүтгэх санаатай биш үйлдэл дээр магадгүй энэ алдсаны төлөө шууд эрүүгийн хариуцлага хүлээх ёстой юу, үгүй юу. Гэтэл цаад мэдээлэл нь өөрөө олон нийтийн мэдээлэл хүлээж авах тэр эрхийг хангах хүрээнд явж байсан бол яах вэ гэдэг. Тэгэхээр энэ дээр түрүүний асуулт маань тэр. Яг энэ ерөнхийлөн заасан буюу 13.14 дүгээр зүйл нь хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн хуулийн этгээдийн гэдэг дээр бас аягүй сайн анхаарах ёстой. Ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр эн илт худал мэдээлэл олон нийтийн нэр хүндэд халдсан гэдэгт чинь ямар нэгэн тодорхой тусгай шалгууруудыг тавьж өгөх ёстой байсан байна гэдгийг итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд зөвшөөрч байгаа юу. Бид энийг хүлээж аваад засах ёстой юу гэдэг асуултыг л асуух гээд байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Энхбаяр гишүүн хариулъя.

Б.Энхбаяр: Уянгахишиг гишүүн яг энэ цэцийн шийдвэрийн гол нюансуудыг ер нь хөндөж асуулаа. Миний хувьд бол энэ цэцийн дүгнэлтийн сая Уянгахишиг гишүүний хөндөж байгаа олон асуудалтай санал 1 байгаа. Санал 1 байх байтугай энэ гүтгэх гэж зүйлийг 2020 оны хавар 4 сард илт худал мэдээлэл болгох ийм гэмт хэрэг болгож өөрчилсөн. Энэ Сэтгүүлчдийн нэгдсэн эвлэлийн шаардлагаар шүү. Тэгээд тэрнийх нь гор нь илүү олон сэтгүүлчид мэргэжлийн алдааныхаа төлөө эрүүгийн ял зэм хүртэх энэ нүглийг хийчихсэн юм. Тэгээд энийг бол тухайн үед нь ерөөсөө буруу байна. Бусад улс оронд бол ийм мэргэжлийн алдааг ерөөсөө эрүүлжүүлдэггүй. Зориуд санаатай, гутаах зорилгоор гүтгэлгийг тарааж байгаа тэр субъектив санаа сэдлийг тогтоож байж энэ эрүүгийн хариуцлага яригддаг. Тэр зааг ялгааг ялгах боломжийг илт худал мэдээлэл тараах гэдэг энэ гэмт хэрэг олгохгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй би өөрөө санал нэг байгаа юм. Энийг залруулах ёстой.

2 дугаарт энэ Эрүүгийн хуульд цэцийн дүгнэлтэд нийтийн албан тушаалтан бол ер нь илүү тэвчээртэй байна шүү. Энэ гэмт хэргийн субъект болж гомдол маргаан гаргаад байдаг асуудал дээрээ илүү хүлцэл тэвчих ёстой шүү гэдэгтэй мөн би санал нэг байдаг. Тийм ч учраас 2021 оны 1 сарын 7-нд Улсын Их Хурлын гишүүнийхээ хувьд улс төрд нөлөө бүхий этгээд албан үүрэгтэй нь холбоотой хардсан, сэрдсэн үйлдлийг гүтгэхэд тооцохгүй гэдэг тайлбар оруулъя гэдэг саналыг би хуулийн төсөл санаачилж гаргаж байсан.

Мөн хуулийн этгээдтэй холбоотой асуудлыг цэцийн дүгнэлт мөн хөндсөн байгаа. Төрийн байгууллага энэ гэмт хэрэг дээр нэр төрд халдлаа гэж, ажил хэргийн нэр хүнд халдлаа гэж гомдоллох эрхгүй шүү гэдгийг мөн Цэцийн дүгнэлт хэлж өгсөн байгаа. 2021 онд мөн би төрийн байгууллага энэ гэмт хэрэг дээр гомдол гаргахгүй шүү. Хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүнд гэдэг бол тэр бизнесийн байгууллагуудын нэр төртэй холбоотой асуудал юм гэдгийг мөн хуулийн төсөл санаачилж байсан. Энэ дээр санал нэг байгаа.

Цэцийн дүгнэлтэд санал нийлэхгүй асуудлууд бас байгаа. Өөрөөр хэлбэл эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанаар тайлбарлагддаг, тодорхой төрлийн гэмт хэрэг дээр шинжийг нь ингэж бич, ингэж тайлбарла, ийм ял шийтгэ гэж Цэц ялын зүйлчлэл рүү, ялын бодлого руу бас орох ийм хүрээ хязгаар байна уу, үгүй юу. Бусад улс оронд хорих ялтай байгаа гэмт хэргийг та нар хорьж болохгүй /минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Баярмаа гишүүн асуултаа асууя. Эрдэнэболд гишүүнийг нэмчхээрэй.

Ж.Баярмаа: Энэ илтэд худал мэдээлэл тараах гээд 13.14-тэй би яг бараг 2 жилийн өмнө танилцсан юм. Анх нөгөө Өнөрөөг асуудал болгож баривчилж яг өдийд шүү дээ. Тэгээд тэндээс яг энэ заалтыг судлаад, энэ ер нь ямар учиртай юм гээд үзэхээр арга байхгүй сэтгүүлчдийн хэвлэн нийтлэх тэр эрхэд халдсан байдаг юм байна лээ. Тийм ч учраас НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл удаа дараа зөвлөмждөө энийгээ эрүүгийн зүйлчлэлээр яллахаа болиоч ээ. Иргэний хуульд оруулаач ээ гэж ингэж зөвлөдөг юм байна лээ. Би бүр тэр Дондов билүү Хүний эрхийн Үндэсний Комиссын хүнтэй хүртэл 2 жилийн өмнө очиж уулзаж байсан. Энэ ер нь яг ямар учиртай юм. Хүний эрх талаасаа энэ үнэхээрийн эрүүгийн зүйл ангиас нь болиулах ёстой юм уу, яах ёстой юм гээд. Тэгээд Хүний эрхийн Үндэсний Комисс бол яг л энийг эрүү биш иргэнээр шийдэх ёстой гэж үздэг юм байна лээ.

Тийм учраас би тэндээс төдийгөөс өдий хүртэл энэнд би бол үнэнч хэвээрээ байгаа. Сая бүгдээрээ ярьж байна. Нийтийн албан тушаалтан буюу улс төрчид гээд. Тэгэхээр энэ чинь явж явж тэд нарын хүлцэх үүргийн тухай бас асуудал болоод байгаа юм. Тэгээд одоо бид нар чинь бас нийтийн албан тушаалтан болоод ингээд явахад яг тэр гүтгүүлэх энэ юм руу, гүтгэлгийн хонгилоор чирүүлж л байгаа л даа. Тэгэнгүүт чинь нэг талдаа энэ чинь нөгөө зоосны 2 тал шиг юм болоод байна л даа. Нэг талдаа бид нар нийтийн албан тушаалтай учир хүлцэх ёстой гэдгийг бид нар хүлцэхээс өөр замгүй. Тэгэхээр аль эрх нь илүү чухал вэ гэдэг. Тэгэнгүүт хамгийн гол бид нарын баримталдаг нэгдэн орчихсон байгаа иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактад бас хоёуланг нь дурдчихсан. Монгол Улсын Үндсэн хуулиар ч гэсэн хүний үг, үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрхийг олгох ёстой гээд 16.16-гаар заачихсан. 17-оор болохоор хүний нэр төр, алдар хүндийг хүндэтгэх ёстой гээд заачихсан. Тэгэнгүүт энэ фактад бас хоёуланг нь заачихсан. Тэгэнгүүт одоо бид нар яг яах ёстой юм бэ гэдэг ийм асуудлын өмнө л тулгарч байна л даа. Тэгэнгүүт сая энэ ярианаас ойлгоход иргэний хуулиар зохицуулаад үлдээе гэхээр мөрдөн байцаалт явагддаггүй учир гүтгэсэн эсэх, илтэд худал мэдээлэл тараасан эсэхийг нь тогтоож болохгүй гэж ойлголоо. Зөв үү. Тэгэхээр ингээд тогтоогдохгүй болохоор ингээд гүтгүүлээд яваад байх нь бас зөв эсэх.

Тэгэхээр асуулт. Яг энэ статистик судалгаа байна уу. Яах вэ, нийтийн албан хаагчид, алба албан тушаалтнууд бол ингээд гүтгүүлээд явж боллоо гэхэд жирийн иргэдийг бас энэ илтэд худал мэдээлэл тараах ийм асуудалд орооцолдуулж сэтгэл зүйн хувьд /минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Нэмэлт 1 минут Баярмаа гишүүн.

Ж.Баярмаа: тийм нийтийн албан тушаалтан бус хүмүүсийн судалгаа байдаг юм уу.

2-т, улс төрчид буюу нийтийн албан тушаалтнууд эргээд хэр их ингэж гомдоллодог юм бэ. Тэгээд гүтгүүлээд байна гээд цагдаад гомдол өгөөд байгаа. Энэ бас судалгаа байдаг юм уу. Тэгээд энийг ер нь яаж шийдэх вэ цаашид. Энэ зөвхөн нийтийн албан тушаалтны тухай асуудал биш ердөөсөө бүх иргэдийг гүтгэх эсэх тухай асуудал яригдаж байгаа учир энэ Эрүүгийн хуульдаа тэр гүтгэх гэдэг зүйл ангийг оруулж болох юм уу. Цаашид ер нь энэ дээр яая гэсэн бодолтой байгаа юм бэ. Аль нэгээр нь нэг тийшээ болгохгүй бол энэ чинь 2 асуудал зэрэг яваад байна л даа. Нэгийг нь хаах гэхээр нөгөөдөх нь нээгдээд, нөгөөдхийг нь нээх гэхээр нөгөөдөх нь хаагдаад. Тэгэхээр энэ дээр Хууль зүйн сайдын хувьд ямар байр суурьтай байгаа вэ.

Тэр гүтгүүлээд байгаа асуудлыг бас яаж цэгцлэх ёстой юм бэ. Гэхдээ сэтгүүлчдийн хэвлэн нийтлэх эрхийг хаахгүйгээр, айлгахгүйгээр, ичээхгүйгээр байнга цагдаагийн үүдэнд .../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Энхбаяр гишүүн хариулъя.

Б.Энхбаяр: Яах вэ, Цэц бол ингээд байгаа юм. Энэ Эрүүгийн хуулийн заалт чинь их ерөнхий байдлаар, тэгээд энийг далимдуулаад хэвлэн нийтлэх эрх чөлөө амыг хаах гэсэн ийм боломжийг олгоод байна. Энэ процессоор чинь далимдуулаад. Энэ юмыгаа бол хууль тогтоогч нарийн журамлаж, цэгцлээч гэдэг 1 асуудал тавиад байгаа юм. Тэрнээс хүний нэр төр хамгаалагдахгүй байна гэж бол байхгүй. Бүр Үндсэн хуульд хүний үндсэн үүрэг байгаа шүү дээ. Хүний нэр төр, хууль ёсны, эрх чөлөөг хүндэтгэх иргэн бүрийн үүрэг байгаад байгаа юм. Энэ хүнийхээ нэр төр, алдар хүндийг хамгаалах нь мөн төрийн иргэнийхээ өмнө хүлээсэн үүрэг байгаад байгаа юм. Энийг Эрүүгийн хуулиар л хамгаалахгүй, Иргэнийхээ хуулиар хамгаалах боломжтой гэж ярьдаг манай хууль тогтоогч гишүүд бол зөндөө байгаа. Гэхдээ би Үндсэн хуулийн цэц дээр маш тодорхой хэлээд байгаа юм. Цахим орчинд нэр нүүрээ нууж, хүнийг гүтгэж байгаа энэ үйлдлүүд бол 2025 оны 11 дүгээр сараас эхлээд хуулийн байгууллага энийг гомдлыг шалгах ямар ч боломжгүй болчихсон юм шүү. Хариуцлага тооцох боломжгүй. Энийг худлаа бие биеийгээ хуураад байх юм байхгүй. Энийг зүгээр 1 жил явуулахад л угаасаа хангалттай нотлогдоно. Энэ хүний нэр төр гэдэг чинь Монголчууд ярьдаг шүү дээ. Нэр хугарахаар яс хугар гэж. Нэр төрд нь халдаад, амиа хорлож байсан бас хүмүүс байгаа шүү дээ. Хүний амины үнэ цэнтэй шүү. Хүний нэр төр гэдэг бол. Үнэгүй юм шиг, гишгэчхэж болдог юм шиг ийм зүйл бол би байж болохгүй гэж боддог. Бие биеийнхээ нэр төрд хүндэтгэлтэй хандах ёстой. Бие биеийгээ бас хууль ёсны хүрээнд хамгаалдаг байх ёстой. Одоо миний хажууд сууж байсан сая Алтанхуяг гишүүн нь намайг 10 жилийн өмнө гүтгэсэн гээд Эрүүгийн хуулиар би яллагдагч болоод явж байсан. Гэхдээ би хууль ёсны дагуу сая энэ зүйл ангиар нь хууль ёсныхоо эрхийг хамгаалаад, гэмт хэрэг үйлдээгүй байна гээд хууль ёсныхоо дагуу би цагаадаад л гарч байсан. Тэрнээс биш энэ чинь бие биеийгээ нөгөө талд нь Үндсэн хуулийн цэц гүтгэж болно гэдэг шийдвэр гаргаж болохгүй байхгүй юу. Ямар ч хүрээ хязгааргүйгээр.

Хэвлэн нийтлэх эрхийн тухай ярьж байгаа бол энэ цагдаагийн байгууллагад өнгөрсөн хугацаанд шалгагдсан хэвлэл мэдээллийн байгууллага хүмүүс бол 20 хувь давж байгаагүй. 80, 90 хувь нь иргэд бие биеийгээ гүтгэж доромжилж байгаа

гомдлыг хянан шийдвэрлэсэн байдаг. Улс төрчид тийм ч олноороо цагдаагийн байгууллагад хэвлэлийнхнийг бас өгөөд байгаагүй. Нэр бүхий 2 улс төрч бол харин байнга өгч байсан асуудал бол харин байсан. Би нэрийг нь хэлээд яах вэ. Манай 2 Их Хурлын гишүүн бол ерөөсөө л бичсэн .../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Болсон уу Баярмаа гишүүн. Сүүлийн 1 минут.

Ж.Баярмаа: Тэгэхээр иргэд голцуу бас өөр хоорондоо илтэд худал мэдээлэл тараах гэдэг энэ зүйл ангиар бие биеийгээ өгөх нь өгөөд, бодвол бас шийтгэгдээд энэ тэр явж байдаг юм шиг байна шүү дээ. Тэгэнгүүт нөгөө талдаа үүнийг чинь далимдуулаад байгаа нөгөө сэтгүүлчид бас үгээ хэлж чадахаа болиод байна гэдэг асуудлыг байнга тавьж байгаа. Тэгэхээр нөгөө түрүүний ярьж байгаа тэр гүтгэх гэдэг зүйл ангийг оруулаад энэ илтэд худал мэдээлэл тараах гэдэг энэ ерөнхий зүйл ангиа болиулах ч юм уу, яг энэ дээр шулуухан ямар хуулийн төсөл эсвэл нэмэлт, өөрчлөлтийг оргуулж ирье гэж бодож байгаа вэ. Та хуулийн сайдын хувьд. Маш тодорхой өнөөдрийн энэ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг авах эсэх бол шал өөр асуудал. Ер нь таны хувь хүний үзэл бодол энэ дээр ямар байгаа вэ. Гүтгүүлэх, гүтгэх гэдэг тэр зүйл ангийг нэмж дахиж оруулах ёстой юм уу. Оронд нь энийгээ болиулах ёстой юм уу.

Ц.Сандаг-Очир: Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Би бол илт худал мэдээлэл тараах гэж гэмт хэрэг байж болохгүй гэж боддог. Худлаа зүйл ингээд гарчихсан байна шүү дээ. Тэр чинь хүн алдаж болно. Санамсар болгоомжгүй байж болно. Гүтгэх гэдгээрээ бол гэмт хэрэг байх ёстой. Өөрөөр хэлбэл гүтгэх гэдгийн цаана зориуд санаатай гүжирдлэг гэсэн утгыг илэрхийлж байдаг. Энэ гүтгэх гэдэг үг нь өөрөө. Өөрөөр хэлбэл санаатай үйлдэл. Энийг зохион байгуулсан, энийг худлаа гэдгийг нь мэдсээр байж зориуд санаатай өгч байгаа идэвхтэй үйл ажиллагааг хэлээд байгаа юм. Тийм учраас энэ бол Эрүүгийн хуулийн хариуцлагатай байх ёстой гэж би үздэг. Улс төрд нөлөө бүхий нийтийн албан тушаалтны тухайд бол илүү тэвчээртэй, хүлээцтэй буюу яг энэ асуудлаар нэр хүндэд нь халдлаа гэж /минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Эрдэнэболд гишүүн асуултаа асууя.

С.Эрдэнэболд: Одоо энэ асуудал дээр туйлшрахад их хэцүү болчихоод байгаа юм. Сая жишээлбэл хуулийн сайд юу гэж хэлж байна гэхээрээ 80 хувь нь иргэд хоорондоо гээд байна тийм үү. Сэтгүүлчдийн өгөөд байгаа мэдээлэл нь нийт гомдлын 80 хувь нь дарга нар өгөөд, нийт хариуцлага хүлээгээд байгаа хүмүүсийн 90 хувь нь сэтгүүлчид байна гэдгийг бичээд байна л даа. Тэгэхээр энэ дээр яг тоо статистик хэрэгтэй болчихоод байгаа юм.

2 дугаарт энэ ямар асуудал вэ гэхээрээ хууль зүйн нэр томьёо хийгээд тэр хууль зүйн нэр томьёоны цаана байгаа зохицуулалт хариуцлагатайгаа зөв уялдуулах тухай асуудал болчихоод байгаа юм. Баярмаа гишүүний асуугаад байгаа зүйлийг би жоохон лавлаадахъя. Дэлгэрүүлээдэхье гэж бодож байна. Одоо саяхныг болтол defamation буюу гүтгэлэг abusement буюу доромжлол гэдэг олон улсын эрх зүйн нэр томьёонд яг ингээд тодорхой санкцуудтайгаа байсаар ирсэн. Одоо хүртэл байгаа. Тэгсэн чинь болохоор Fake news гэдэг хэллэг гарч ирж байгаа юм. Худал мэдээ цаашаагаа тэр нь задраад deep fake буюу нөгөө AI хүний дүрсийг, дуу хоолойг ингээд орлуулаад явчхаж байгаа тийм үү. Тэгээд би энийг ингээд судалсан чинь анх 1835 онд бол Америкийн хэвлэлээр гарч эхлээд, 1889 оноос ихсээд, 1920-оод оныг

хүртэл яг энэ Fake news гэдэг хэллэг ашиглагдаж байгаад, тэгээд байхгүй болчихсон юм байна. Тэгээд 2016 онд Америкийн Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр энэ дахиад интернэт хэрэглээ болон энэ сошиал медиагаас үүсэж гарч ирээд, 2017 онд collins dictionary буюу толь бичигт энэ fake news гэдэг хэллэг бүр яг ингэж нарийн тодорхойлолт бүхий тусгалаа олсон байгаа юм. Тэгээд үүний ар дээр буюу 2018 оноос өгсүүлээд олон улсад яг энэ fake news гэдгийг эрх зүйгээр яаж зохицуулах вэ гэдэг асуудлууд тавигдсан. Тэгэхээр нөгөө бид нарын ойлгоод байдаг уламжлалт доромжлол, гүтгэлэг буюу defamation, abuseмент гэсэн 2 ойлголтоос илүү нарийн зохицуулалтыг олон улсын эрх зүйд шаардаад байгаа. Тэгэнгүүт манайд ямар асуудал үүсчихсэн бэ гэхээрээ яг нөгөө энэ нэр томъёо нэгэнт санкцтай холбогдож байгаа юм бол хариуцлага хүлээлгэх процесстой холбогдож байгаа юм бол үүнийгээ хууль дээрээ нарийвчилж тодорхойлох шаардлагатай болчихсон. Тэгэхгүй болохоор нэг бодол бол энэ сэтгүүлчдийг ингээд байна гэдэг нэг асуудал. Нөгөө талд нь болохоор үгүй ээ, наадах чинь хүний нэр төр, алдар хүнд эрх зүйгээр хамгаалах ёстой гэдэг ийм туйлшралын сэдэв болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр яах вэ гэхээр яг нөгөө хар, цагаанаар нь ялгах боломж байгаа юм. Тухайлбал, тэр үр дагавар тийм үү. Тэр тухайн мэдээ fake news буюу хуурамч мэдээлэл defamation байсан юм уу, abuseмент байсан юм уу. Гүтгэлэг байсан юм уу, доромжлол байсан юм уу. Түүнийг яг ямар шалгуураар тогтоох юм. Тэрнээс болоод ямар үр дагавар үүсчихсэн юм. Хүн амиа хорлочихсон юм уу, эсхүл эрүүл мэндээрээ хохирчихсон юм уу. Яг яачихсан ч гэдэг юм уу. Тэгэхээр энэ зохицуулалтыг бид нар нарийвчлахгүй бол хурал даргалагч цаг дуусчхаад, 1 минут сунгаад авчихъя.

Ц.Сандаг-Очир: Эрдэнэболд гишүүн 1 минут сунгая.

С.Эрдэнэболд: Тэгэхээр яг энэ жишээлбэл бид нар equal right, equal protection 2-ыг ялгаж салгаж бичихгүй хэвээрээ байгаад байгаа байхгүй юу. Яг энэ шиг хууль зүйн нэр томъёоны хувьд шинэ тутам үүсчихсэн байхгүй юу. Өнөөдөр 2025 оны 12 сарын 30. Тэгэнгүүт 2017 онд энэ нэр томъёо чинь дөнгөж толь бичиг рүү орж ирээд, тэрнээс хойшоогоо хууль зүйн нэр томъёо дээр өөр өөрийн тусгалаар яваад байгаа юм. Англо-Саксон дээр түрүүлж явж байгаа. Ром-Герман араас нь явж байгаа байхгүй юу. Тэгэхээр ер нь энэ дээр юу гэж хэлэх гээд байна гэхээр цаашлаад энэ асуудлыг бид нар илүү нарийсгах, эрх зүйн ойлголт буюу legal defamation гэдэг зүйл хууль зүйн нэр томъёоны тайлбарыг нь нарийсгаад, тэрийгээ юу гэж ойлгох юм гэдгээ ард нь өгөхгүй бол болохгүй нь гэдэг саналыг л хийх гээд байгаа юм. Тэгэхээр энэ дээр Энхбаяр сайд яг ямар судалгаанууд байна. Яах вэ, энэ асуудал дээр бид нар дэмжсэн, дэмжээгүй гээд явчихна. Аль нэг нь баярлаад, аль нэг нь гомдоод үлдэх гээд байгаа байхгүй юу. Тэгэхдээ энийг цааш нь нарийн гаргалгаа гаргах ёстой болчихоод байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Энхбаяр гишүүн хариулъя.

Б.Энхбаяр: Үнэн. Үнэн. Энийг бид нар аль нэг тал руу нь сэтгэл хөдлөлөөр шийдэж болохгүй байгаад байгаа юм. Одоо ингээд Эрүүгийн хариуцлагагүй, ямар ч ял шийтгэлгүй болчих нь бол Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний нэр төр, алдар хүндийг бид нар төр ерөөсөө ингээд хамгаалалтгүй орхичхож байгаа байхгүй юу. Гомдол гаргаад хамгаалж чадахгүй. Энийг тэгээд аль хүртэл нь явах юм. Амиа хорлох хүртэл нь явуулах юм уу одоо мэдэхгүй. Нөгөө талд нь маш олон ийм юмны цаана зохион байгуулалттай одоо та ярьж байна. 2016 оноос хойш гэдэг чинь үндсэндээ Америкийн сонгуульд гаднын тусгай албад цахим орчноор дамжуулж гүтгэлэг тарааж нөлөөлсөнтэй холбоотой байхгүй юу. Тэгэхээр энэ ганцхан хүний

нэр төрөөс гадна тухайн улсын ард түмэн өөрийнхөө төлөөлөгч, засаг төлөөлөгчөөр хэнийг сонгох вэ гэдэг тэр чөлөөт сонголтод нөлөөлдөг. Цаашдаа тухайн улсыг хэн нь засаглах вэ гэдгийг гадаад улсаас нөлөөлж мэдэж болдог ийм дархлаагүй үндэстэн, улсын тухай үр дагавар руу бид бас орох гээд байгаа байхгүй юу. Өөрөөр хэлбэл энэ бас үндэсний аюулгүй байдлын асуудал. Цахим халдлага нөлөөллийг тусгай албадын зүгээс идэвхтэй явуулж байгаа. Ялангуяа орчин үеийн дайн бол кибер дайн болсон. Мэдээллийн дайн болсон, нөлөөллийн дайн болсон. Ялангуяа дархлаагүй, сэтгэл хөөрөлд автдаг ийм үндэстэнд тархи толгойг нь хэрхэн яаж угаах вэ гэдэг туршилтуудыг байнга хийж байдаг. Худал гүтгэлгийн цаана ганцхан хүн өртдөггүй. Энэ хам шинжтэй. Сэтгэл гутралд ордог, айдаст автдаг ийм олон дам нөлөөлөлтэй. Ялангуяа ахмадуудын хувьд янз бүрийн хүчирхийллийн худал мэдээллүүдийг сонсоод, уншаад л нойр нь хүрэхгүй. Зүрх судасны өвчин нь хүрдэг. Ийм л байгаа шүү дээ. Тухайн хүн яахгүй ч байж болно. Би бол хэр баргийн гүтгэлэг, доромжлолыг ерөөсөө яадаг ч үгүй. Тэгэхдээ сүүлд ингээд 3 гишүүн зодолдоод, нүд нь өвдчихсэн юу билээ нүдэндээ цохиулчихсан гээд намайг постер явуулсныг манай ээж бол бие нь муудсан байна лээ. Итгээд ... /минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Цэцийн дүгнэлттэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Тэмүүжин гишүүнээр тасаллаа. Тэмүүжин гишүүн үгээ хэлье.

Х.Тэмүүжин: Эрүүгийн хуулийн энэ заалттай хувь заяагаар их олон юмаар жоохон холбогдсон. 2015 онд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга хийгдэж байхдаа Эрүүгийн хуулиас доромжлох, гүтгэх гэдэг 2 гэмт хэрэг зүйлийг халж байсан юм. 2019 онд худал мэдээлэл тараах гэдэг нэртэйгээр буцаж орж ирэхэд нь бас нэлээн эсэргүүцэж байсан. Үндэсний телевиз дээр Энхбаяр, бид 2-ын бараг бүтэн мэтгэлцээн байгаа байх. Энд хэд хэдэн юмыг салгаж ойлгох хэрэгтэй. Уламжлалт гүтгэх гэдэг гэмт хэрэг, одоо яригдаж байгаа худал мэдээлэл тараах гэдэг гэмт хэрэг 2 ялгаатай юу гэдэг талаар бид бас ярилцах ёстой. Монголд бол одоогоор бол ямар ч ялгаагүй. Худал мэдээлэл тараах гэдэг гэмт хэргийн доор гүтгэх гэмт хэрэг гээд биччихсэн. Худал мэдээлэл тараах гэдэг гэмт хэрэг сүүлийн 15 жилд гарч ирсэн шинэ төрлийн гэмт хэрэг. Анх энэ гэмт хэргийг хуульчилсан улс орнууд нь бол жоохон захиргаадалтын буюу жоохон хүчирхийллийн аргаар улс орноо удирддаг хүмүүс байсан. Ардчилсан буюу чөлөөт нийгмийн талаас бол нэлээн их шүүмжлэл дагуулдаг байсан боловч Англиас эхлээд энэ гэмт хэргийг хуульчлаад эхэлсэн. Яагаад вэ гэхээр энэ өөрөө цахим платформууд хөгжөөд, энэ сошиал дээр ямар нь мэдэгдэхгүй мэдээллүүд их тардаг болсноос улбаатайгаар нөгөөтээгүүр энэ сошиал орон зайг гаднаас нь дотоод улс төрийн сонголтыг хийхэд нь улс орнуудад нөлөөлдөг болсноос холбоотойгоор энэ төрлийн гэмт хэргийг иргэний эрхээ хамгаалаад хуульчлахгүй гэж ярьж байсан нь өөрсдөө сул тал болж эхэлсэн учраас зарим улс орнууд хуульчилж эхэлсэн.

Гэхдээ хуульчлахдаа ийм ялгаатай. Хэн нэгэн хүн гүтгэх, гүтгэхгүй, хэн нэгний нэр төр, алдар хүндийг гүтгэхгүй, зүгээр илт худал мэдээллийг зохион байгуулалттайгаар олон хүрээнд тараагаад, тэрнээс нь болоод нийгэмд хүчирхийлэл гарсан, эмх замбараагүй байдал бий болсон, нийгэмд талцаж хуваагдсан, хүн амь насаа алдсан, эд хөрөнгөөрөө өргөн хэмжээнд хохирсон гэх мэтчилэн ингээд үр дагавар гараад ирэхээр энэ үр дагавар нь юунаас болов. Худал мэдээллээс боллоо. Худал мэдээллийг нь хэн тараав гэж хариуцлага ярьдаг систем хийж эхэлсэн. Энэ бол худал мэдээлэл тарах гэмт хэрэг. Хүн гүтгэсэн байхыг ерөөсөө шаардахгүй.

Гүтгэх гэмт хэрэг нь хүний нэр төр, алдар хүндтэй холбоотой. Бизнесийн амжилттай холбоотой ийм 2 ялгаатай гэмт хэргийг бид хольж хутгаад байгаа юм. Хольж хутгаад байгаа юм. Тэгэхээр ялгаатай юу гэдгээ ярих ёстой.

Худал мэдээлэл тараах гэмт хэргийг яг энэ агуулгаар нь хуульчлах уу, үгүй юу гэдэг бол шинэ сонголтын асуудал. Гүтгэх гэмт хэргээ Эрүүгийн хуульдаа байлгах уу, үгүй юу гэдэг бол уламжлалт гэмт хэргээ иргэний эрхийг хамгаалах зорилгоор бичих үү, үгүй юу гэдэг асуудал. Энэ 2-ыг замбараагүй хольж хутгасан болоод, ийм үйл явц болсон чинь юу болоод хувирсан бэ гэхээр энэ худал мэдээлэл тараах гэмт хэргийн ард төр өөрөө нэр төртэй болоод хувирсан. Одоо та бүхэн анзаарвал төрийн байгууллагууд гомдол санал гаргаад, өөртөө байгаа нөөцөөрөө иргэн рүү бидний ажил хэргийн нэр хүндэд халдлаа гээд иргэнээ хариуцлагаар хуулиар айлгадаг болоод хувирчихсан байгаа шүү.

Уламжлалт гүтгэх гэмт хэрэгт чинь хохирогч нь хэн юм бэ гэхээр иргэн байсан юм хуучин. Тэгсэн чинь одоо энэ Эрүүгийн хуулиар юу болоод хувирсан гэхээр албан тушаалтан төр өөрөө ороод ирчихсэн. dignity буюу нэр төр гэдэг ойлголт чинь зөвхөн human dignity гээд хүнд байдаг ойлголт. Төрд байдаггүй. Гэтэл төр өөрөө гомдогч болоод, иргэнээсээ илүү нэр төртэй, иргэнээсээ илүү үнэ цэнтэй болоод хувирчихсан тийм гажуу хандлага энэ хуулийн чинь ард бий болчихсон. Бидний ярихгүй байгаа нэг өнцөг чинь энэ шүү.

Хэвлэлийн эрх чөлөө, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө гэх мэтчилэн олон зүйлтэй холбоотой үл ойлгогдох байдал байгаа гэдэг бол үнэн. Тийм учраас хууль зүйн бодлогын хувьд ямар байх юм бэ гэдгээ бид .../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Сая Тэмүүжин гишүүн гүтгэх, доромжлох, худал мэдээлэл тараах гээд бас ялгаатай талаар хэлчихлээ. Дээрээс нь би зүгээр нэмээд иргэний эрх зүйн хамгаалалтад иргэний нэр төр, алдар хүнд чинь өөрөө иргэний эрх зүйн хамгаалалтад байгаа. Эрүүгийн эрх зүйн хамгаалалтад ямар хэмжээгээр байх юм бэ, ямар цар хүрээ байх юм бэ гэдгээ бид нар одоо бол ярих цаг нь болсон. Тийм учраас би бол Үндсэн хуулийн цэцийн энэ дүгнэлтийг дэмжиж байгаа. Тэгээд Иргэний хууль дээр нэг юмыг бид нар маш сайн анзаарах хэрэгтэй. Зарим гишүүд буруу ойлгоод байх шиг байна. Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол гэж байгаа юм. Нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар тараасан хэлбэрээрээ дахиж тухайн мэдээллээ няцаах үүргийг хүлээнэ. Тэгэхээр нотлох үүрэг нь хэнд байдаг вэ гэвэл нөгөө иргэний шүүх дээр оччихлоор мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж чадахгүй ингээд хохирчих юм биш үү л гэдэг л асуулт бас энэ танхимд нэлээн гарлаа шүү дээ. Иргэний хуулиар юу вэ гэвэл тэр нотлох үүрэг нь тэр худал мэдээлэл тараасан хүнд байгаа. Хэрвээ худал мэдээлэл тараасан хүн энэ мэдээлэл үнэн юм. Баасанжаргалын тухай энэ мэдээлэл үнэн юм гэдгийг шүүхийн өмнө нотолж чадахгүй бол шууд тэрийгээ сэргээгээд, энэ худал мэдээлэл байсан юм гэдгээ яг тараасан тэр мөрөөрөө явах ёстой байдаг. Тэгэхээр нөгөө иргэний эрх зүй, эрүүгийн эрх зүй гээд энэ нөгөө хамгаалалтуудын объект нь өөр бөгөөд процесс нь бас дахиад ялгаатай. Нөгөө нотлох үүрэг нь хэнд байгаа вэ гэдгээсээ хамаараад ялгаатай гэсэн үг. Тэгэхээр бид нар бол хууль тогтоомж дээрээ нарийвчилсан зохицуулалтуудаа оруулаад, ялангуяа хариуцлагын төрлүүд дээрээ бас оруулаад, ер нь бол Зөрчлийн хууль дээр нэмж оруулах ийм бол саналтай

байгаа. Тэгээд манай Байнгын хорооны гишүүд энэ дүгнэлтийг хэрхэн хүлээж авах вэ гэдгээс бас мэдээж хамаарах байх.

Гэхдээ бид нар маш олон жил НҮБ-ын хүний эрхийн төлөв байдлын тайлан явуулаад, буцаад НҮБ болоод НҮБ-ын гишүүн орнуудаас ирж байгаа тайлан илтгэлүүд дээр Монгол Улсад өгч байгаа бас нэг том хэсэг нь яг энэ асуудал байгаа. Дандаа ингэж иргэний нэр төр, алдар хүнд гэдэг нэрийн цаана хэвлэлийн эрх чөлөөг боомилоод байна. Хэвлэн нийтлэх эрх чөлөөгөө та нар хязгаарлаад байна. Үүнийхээ зааг ялгааг гаргах болжээ гэж маш олон зөвлөмж, саналууд бид нар авдаг.

Нөгөө талаараа бид нар үүнтэй зэрэгцээд Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг Хууль зүйн яам бол өргөн бариад, бид нар хэлэлцэх эсэхийг нь дэмжчихсэн байгаа. Энийг бас түргэвчлүүлж, энэ хуулийг батлахад 1 том ташуур боллоо гэж харж байгаа. Тэгэхээр бид нар бол аль аль байдлаар нь цогц байдлаар энэ асуудлыг харах ёстой. Цэцийн дүгнэлт дээр миний бол бүр санал нэгдэж байгаа 1 зүйл юу вэ гэвэл сэтгүүлчийн өөрөө удирдах ёсны байгууллага, өөрсдийнхөө энэ ёс зүйн хэм хэмжээ энэ асуудлыг шийддэг энэ тогтолцоог нь хөгжүүлэх эрх зүйн орчныг бол бас хууль тогтоогчид бүрдүүлэх ёстой. Тэгээд энэ дээр бас манай хууль тогтоогчид бас хариуцлага хүлээгээд, энэ өөрөө удирдах ёсны байгууллагын хөгжлийн асуудлыг нь бид нар бол бас нээлттэй болгох ёстой гэдэг ийм байр суурьтай байгаа. Тийм учраас бас Хууль зүйн байнгын хорооны бусад гишүүдээ дэмжихийг хүсэж байна.

Ц.Сандаг-Очир: Эрдэнэболд гишүүн үг хэлье.

С.Эрдэнэболд: Тийм сая Тэмүүжин гишүүн ч гэсэн хэлээд байгаа зүйл нь энэ шинэ тутам нийгмийн харилцаа цахим байдлаар ингээд үүсчихээр бид нар ер нь ингээд хууль зүйн нэр томъёоных нь хувьд нь зохицуулалттай нь уясан, нөгөө нарийвчилсан зохицуулалт зайлшгүй хэрэгтэй байгаа нь харагдаж байна л даа. Жишээлбэл, бид нар 2 өөр юмыг 1 сагсанд хийчхээд байгаа. 1 нь болохоор тэр Fast check Mongolia гээд центрээс нотлох баримтын түвшинд биш зүгээр баримтын түвшинд асуудлыг ингээд шалгадаг ийм байгууллагаас гаргаж байгаа мэдээллээр бол манай улсад хийж байгаа тэр сонгуулийн үеэр гарсан мэдээнүүд гадаад улсаас илтэд зохион байгуулалттай, ашиг сонирхолтой зүйлүүд байна гэж үзэж байгаа.

Дээрээс нь тэр та бүхэн харж байгаа бол фэйсбүүк дээр зарим улсын нэртэй доор нь step paid буюу төлбөртэй ийм зүйлүүд явж байгаа юм. Тэгээд энэ чинь яаж байна гэхээрээ нөгөө хүмүүсийг манипуляц хийх, сонголт хийх, шийдвэр гаргалтад нөлөөлөх гэсэн ийм зүйлүүд яваад байдаг. Цаад утгаараа, шууд утгаараа үндэсний аюулгүй байдалтай холбоотой зүйлүүд ч яваад байдаг. Бодвол энийг ингээд л хууль, тагнуулынхан судалж л байдаг байлгүй дээ. Гэтэл нөгөө талд нь хүний эрхийн асуудал байгаад байдаг. Тэгэхээр энэ 2-ыг ингээд 1 сагсанд хийх боломжгүй болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр Их Хурал өөрсдөө ажлаа хийгээд, энэ зохицуулалтаа нарийвчлахгүй бол одоо сэтгүүлчдээс ч юм уу ирээд байгаа гомдол бол бид нарыг яллах, цаазлах л юм хийх гээд байна л гэдэг зүйл байгаад байгаа юм. Гэтэл үүнийхээ нөгөө санкцтай нэгэнт юм явж байгаа юм чинь хууль зүйн нэр томъёоныхоо хувьд маш тодорхой нарийн гаргалгаа бүхий байх ёстой болчихоод байгаа юм. Тэгээд одоо та бүхэн мэдэж байгаа шүү дээ. Ковидоос хойш ковидын үеэр бол шинжлэх ухаан технологийн хурд 2 жилийн дотор 12 жилийн хурдаар хөгжчихсэн. Үүнээс өмнө болж байсан 1 тохиолдол бол дэлхийн 2 дугаар дайны 1941-1945 онд шинжлэх ухаан 4 жилийн дотор 35 жилийн хурдаар хөгжиж байсан гэсэн ийм тооцоолол байдаг. Энэ ковидоос хойш энэ технологийн хурд нь эргээд та

бүхэн ингээд ажиглаад үзээрэй. Тэгэх юм бол яг энэ fake news ч юм уу энэ deer fake эд нар яг үүнтэйгээ адил хурдаар хөгжчихөж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ зохицуулалт шаардагдаж байна уу. Шаардагдаж байгаа. Тэгээд тэр нь ямар төрлийн зохицуулалт байх юм гэхээр бид нар ингээд шууд яллана, хорино гэхээсээ өмнө нь энэ тодорхойлолтуудаа нарийвчлах зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ бол Улсын Их Хуралд нийгмээс өгч байгаа даалгавар. Хэм хэмжээ дээр нь бид нар маш сайн углуургатай авч үзэх, ойлголтын зөрүүгээ арилгаад аль болохоор ингээд нэг долгион дээр ойлголтоо тааруулах ёстой л гэж үзэж байгаа.

Гэтэл яг өнөөдрийн нөхцөл байдал дээр би хувь хүнийхээ итгэл үнэмшлээр хэлэхэд Цэцийн шийдвэрийг дэмжихээс өөр аргагүй. Яагаад гэхээр энэ хууль тогтоож байгаа энэ тодорхойлолтууд бүхий яг энэ зохицуулалтууд нь өөрөө асар олон тодорхойгүй зүйл давхцал, гөрдөж ашиглах боломжтой ийм зүйлүүд байгаад байгаа юм. Тийм учраас Хууль зүйн байнгын хороо дээр манай Цогтбаатар дарга, бид нар бүгдээрээ энийг бас энэ хүрээндээ ярилцаад, энийг ингээд энэ чигээр нь үлдээхгүйгээр цаашид ахиад зохицуулалтыг нь нарийсгах зайлшгүй шаардлагатай юм байна гэж байгаа.

Тэгээд сая Баасанжаргал гишүүн бас энэ дээр нэг санал хэллээ. Энэ дээр хэдүүлээ бас шаардлагатай гэж үзвэл яг энэ дээр нь ажлын хэсэг гаргаад ч гэдэг юм уу ажиллах боломжтой л гэж харж байна.

Ц.Сандаг-Очир: Үндсэн хуулийн цэцийн 10 дугаар дүгнэлттэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2.2 дахь заалт, Байнгын хороод цэцийн дүгнэлтийг хэлэлцэн санал, дүгнэлт гаргахдаа холбогдох хууль, тогтоолын Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн зүйл, хэсэг заалт бүрээр, хэрэв Монгол Улсын Үндсэн хуулийн хэд хэдэн заалтыг зөрчсөн бол Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалт бүрээр тус тусад нь санал хураалт явуулах гэж заасны дагуу санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгэе. Дэмжихгүйгээ илэрхийлж түрүүнд 1, 2 гишүүн дэмжихгүй гээд гараад явж байх шиг байна лээ. Тэгэхдээ бүгд бол мэдэхгүй. Мэр сэр гишүүд. Санал хураалтдаа бэлдье. Бэлдчихсэн үү. Байнгын хорооны саналаар шүү. Бэлдчихсэн биз. Санал хураалт 4 санал хураалттай.

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “... эрх чөлөө, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёолоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 15 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 46,7 хувиар дэмжигдсэнгүй.

2 дахь санал хураалт.

Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх

хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтын “... үзэл бодлоо чөлөөт илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, ... эрх чөлөөтэй. ...” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 15 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 46,7 хувиар санал дэмжигдсэнгүй.

3.Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь заалтын “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. ...” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 15 гишүүнээс 6 гишүүн дэмжиж, 40 хувиар санал дэмжигдсэнгүй.

4.Эрүүгийн хуулийн 13.14 дүгээр зүйлд “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 15 гишүүнээс 7 гишүүн дэмжиж, 46,7 хувиар санал дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийг хэлэлцэж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 10 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн танилцуулах нь хэн байна. Баасанжаргал гишүүн танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье. Хуралдаандаа идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.

17.36 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ